

Администраторын Заавар

Агуулга

Зохиогчийн эрх

Худалдааны тэмдэг

Энэхүү гарын авлагын тухай

Тэмдэг тэмдэглэгээ.	7
Энэхүү гарын авлагад ашигласан тодорхойлолт.	7
Үйлдлийн системийн лавлагаа.	7

Оршил

Гарын авлагын бүрэлдэхүүн.	9
Энэхүү зааварт ашигласан нэр томъёо.	9
Нөхцлүүд.	9
Сүлжээний орчны жишээ.	12
Принтерийн холболтын төрлүүд.	14

Принтерийн тохиргоо ба менежмент

Принтерийн тохиргоо ба удирдлагын дараалал.	16
Принтерийн сүлжээний холболт.	17
Хэвлэх функцийн тохиргоо.	17
Шуудангийн серверийн тохиргоо.	17
Хамгаалалтын тохиргоо.	17
Үйл ажиллагаа ба менежментийн тохиргоо.	18

Сүлжээний холболт

Сүлжээний холболт хийхийн өмнө.	19
Холболтын тохиргооны талаар мэдээлэл цуглуулах.	19
IP хаягийн хуваарилалт.	20
DNS сервер болон прокси сервер.	20
Хянах самбараас сүлжээ рүү холбох.	21
IP хаяг оноох.	21
LAN руу холбох.	25

Функцийн тохиргоо

Тохиргоо хийх програм.	27
Web Config (Төхөөрөмжийн вэб хуудас).	27
Хэвлэх функцийг ашиглах.	28

Сервер/Түншийн холболтын хэвлэх тохиргоо.	28
Peer to Peer холболтын хэвлэх тохиргоо.	32
Хэвлэх үндсэн тохиргоо.	34
Шуудангийн серверийг тохируулах.	38
Шуудангийн серверийн тохиргооны зүйлс.	39
Шуудангийн серверийн холболтыг шалгах.	40
Системийн тохиргоо хийх.	42
Хянах самбарыг тохируулах.	42
Идэвхгүй үеийн эрчим хүч хэмнэх тохиргоо.	43
Цагийн сервертэй огноо ба цагийг синхрончлох.	44
AirPrint Setup.	44
Epson Connect үйлчилгээ ашиглах.	45
Epson Open Platform ашиглах.	45
Epson Open Platform Тойм.	45
Epson Open Platform-г тохируулах.	45
Баталгаажуулах төхөөрөмжийг тохируулах.	46

Бүтээгдэхүүний хамгаалалтын тохиргоо

Бүтээгдэхүүний аюулгүй байдлын онцлогуудын танилцуулга.	47
Администраторын нууц үгийг тохируулах.	48
Хянах самбараас администраторын нууц үгийг тохируулах.	48
Web Config ашиглаж администраторын нууц үгийг тохируулах.	48
Хавтангийн ажиллагааг удирдах.	49
Тохиргоог түгжих идэвхжүүлэх.	50
Тохиргоог түгжих зүйлс нь Принтерийн тохиргоо цэсэнд байна.	50
Боломжтой байгаа онцлогуудыг хязгаарлах.	53
Хандалтын хяналтыг тохируулах.	53
Гадаад интерфэйсийг идэвхгүй болгох.	55

Үйл ажиллагаа ба удирдлагын тохиргоо

Администратор хэлбэрээр принтерт нэвтрэх.	56
--	----

Агуулга

Web Config ашиглан принтерт бүртгүүлэх.	56
Принтерийн мэдээллийг баталгаажуул.	56
Хянах самбараас мэдээллийг шалгах.	56
Web Config-с мэдээлэл шалгах.	57
Ямар нэг зүйл болвол э-шуудангаар мэдэгдлүүд хүлээн авах.	58
Э-шуудангийн мэдэгдлийн тухай.	58
Э-шуудангийн мэдэгдлийг тохируулах.	58
Програмыг шинэчлэх.	60
Хянах самбарыг ашиглан Принтерийн техник програм хангамжийг шинэчлэх.	60
Web Config ашиглаж програмыг шинэчлэх.	61
Интернетэд холболгүйгээр үйлдвэрийн програмыг шинэчлэх.	61
Тохиргоог нөөцлөх.	62
Тохиргоог экспортлох.	62
Тохиргоог импортлох.	62

Асуудлыг шийдэх

Асуудал шийдвэрлэх зөвлөгөө.	64
Принтерийн төлвийг шалгах.	64
Алдааны зурвас шалгах.	64
Сүлжээний холболтын тайланг хэвлэх.	67
Харилцаа холбооны төлвийг шалгах.	73
Холболтын тест хийх.	77
Сүлжээний тохиргоог эхлүүлэх.	78
Асуудлын тохиолдол.	80
Web Config-т хандах боломжгүй.	80

Хавсралт

Сүлжээний програмын танилцуулга.	82
Epson Device Admin.	82
EpsonNet Config.	82
EpsonNet Print (Зөвхөн Windows).	83
EpsonNet SetupManager.	83
Хянах самбараас (WPS) Wi-Fi-н тохиргоог тохируулах.	84
Түлхэх товчийг тохируулж (WPS) Wi-Fi- н тохиргоог хийх.	84
PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS).	85
Wi-Fi Direct (Энгийн AP) холболт ашиглах.	86
Хянах самбараас Wi-Fi Direct (Энгийн AP) идэвхжүүлэх.	86
Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог өөрчлөх.	86

Холболтын аргуудыг өөрчлөх.	87
Ethernet холболтоос Wi-Fi холболт руу солих.	87
Wi-Fi холболтоос Ethernet холболт руу солих.	88
Принтерийн портыг ашиглах.	89
Тохиргоо-н цэсийн сонголтууд.	89
Принтерийн тохиргоо-н цэсийн сонголтууд.	90
Хэвлэлт тоолуур-н цэсийн сонголтууд.	98
Хангамжийн төлөв-н цэсийн сонголтууд.	98
Засвар үйлчилгээ-н цэсийн сонголтууд.	98
Хэл/Language-н цэсийн сонголтууд.	99
Принтерийн төлөв/Хэвлэлт-н цэсийн сонголтууд.	99

**Байгууллагын нарийвчилсан
аюулгүй байдлын тохиргоо**

Аюулгүй байдлын тохиргоо ба аюулаас урьдчилан сэргийлэх.	102
Аюулгүй байдлын онцлогийн тохиргоо.	103
SSL/TLS-н принтертэй хийх харилцаа.	103
Дижитал гэрчилгээний тухай.	103
CA-эрхтэй гэрчилгээг авах ба импортлох	104
CA-эрхтэй гэрчилгээг устгах.	108
CA Certificate тохируулах.	108
Протоколыг ашиглан хянах.	112
Протоколыг хянах.	112
Таны идэвхжүүлэх болон салгах боломжтой протоколууд.	112
Протоколын тохиргооны зүйлс.	113
IPsec/IP шүүлт ашигласан шифрлэгдсэн харилцаа.	116
IPsec/IP Filtering-н тухай.	116
Өгөгдмөл бодлогыг тохируулах.	117
Бүлгийн бодлогыг тохируулах.	121
IPsec/IP Filtering-н тохиргооны жишээнүүд.	128
IPsec/IP шүүлтийн гэрчилгээг тохируулах.	129
Принтерийг IEEE802.1X сүлжээтэй холбох.	130
IEEE 802.1X сүлжээг тохируулах.	130
IEEE 802.1X-н гэрчилгээг тохируулах.	132
IEEE802.1X сүлжээний статусыг шалгах.	133
Нарийвчилсан аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх.	134
Аюулгүй байдлын тохиргоог сэргээх.	134
Сүлжээний хамгаалалтын онцлог үйлчилгээг ашиглах асуудлууд.	135

Агуулга

Дижитал гэрчилгээг ашиглахтай
холбоотой асуудлууд. 137

Зохиогчийн эрх

Seiko Epson Corporation-н урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрлийг авалгүйгээр энэхүү хэвлэмэл материалын ямар нэгэн хэсгийг дахин боловсруулах, эсвэл мэдээллийн системд хадгалах болон ямар нэг хэлбэрээр, эсвэл ямар нэгэн байдлаар, электрон, механик, фото хуулбар, бичлэг, эсвэл өөр замаар дамжуулж болохгүй. Энд агуулагдсан мэдээллийг ашиглахтай холбоотойгоор ямар нэг патентийн хариуцлагын асуудал үүсэхгүй. Түүнчлэн, энд агуулагдсан мэдээллийг ашиглахаас үүдэн гарсан хор хохирлыг хариуцахгүй. Энд агуулагдсан мэдээлэл нь зөвхөн Epson-н бүтээгдэхүүнийг ашиглахад зориулан гаргасан болно. Бусад бүтээгдэхүүнийг хэрэглэхийн тулд энэхүү мэдээллийг ямарваа байдлаар хэрэглэсэн хариуцлагыг Epson хүлээхгүй.

Осол зөрчил гаргасан, буруу хэрэглэсэн, эсвэл буруугаар ашигласан, дүр мэдэн өөрчлөлт оруулсан засвар хийсэн, эсвэл энэхүү бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулсан, эсхүл (АНУ-с бусад газар) Seiko Epson Corporation-н ашиглалт, засвар үйлчилгээний зааварчилгааг чанд мөрдөж чадаагүйгээс энэхүү бүтээгдэхүүний худалдан авагч, гуравдагч этгээдийн гаргасан хор хохирол, алдагдал, зардал, зарлагыг энэхүү бүтээгдэхүүнийг худалдан авагч, эсвэл гуравдагч этгээдийн өмнөөс Seiko Epson Corporation болон түүний салбар компаниуд хариуцахгүй.

Epson-н үндсэн бүтээгдэхүүн, эсвэл Epson-н Seiko Epson Corporation-р баталгаажуулсан бүтээгдэхүүн гэж тогтоосноос бусад ямарваа хэрэглээний бүтээгдэхүүн, эсвэл аливаа ашиглах сонголтоос үүдэн гарах ямарваа хор хохирол, асуудал бэрхшээлийг Seiko Epson Corporation болон түүний салбар компани хариуцахгүй.

Seiko Epson Corporation-н Epson-н баталгаажуулсан бүтээгдэхүүн гэж тодорхойлсноос бусад интерфэйсийн кабель утсыг ашигласнаас үүдэх цахилгаан соронзон цохилтоос үүдэн гарах ямарваа хор хохирлыг Seiko Epson Corporation хариуцахгүй.

© 2019 Seiko Epson Corporation

Энэхүү заавар, энэхүү бүтээгдэхүүний техникийн тодорхойлолтын агуулгыг аливаа мэдэгдэл өгөлгүйгээр өөрчилж болно.

Худалдааны тэмдэг

- ❑ EPSON® нь бүртгэлтэй худалдааны тэмдэг бөгөөд EPSON EXCEED YOUR VISION буюу EXCEED YOUR VISION нь Seiko Epson Corporation-н худалдааны тэмдэг болно.
- ❑ Google Cloud Print, Chrome, Chrome OS, and Android are trademarks of Google Inc.
- ❑ Microsoft®, Windows®, Windows Server®, and Windows Vista® are registered trademarks of Microsoft Corporation.
- ❑ Apple, Mac, macOS, OS X, Bonjour, ColorSync, Safari, AirPrint, iPad, iPhone, iPod touch, and iTunes are trademarks of Apple Inc., registered in the U.S. and other countries.
- ❑ Use of the Works with Apple badge means that an accessory has been designed to work specifically with the technology identified in the badge and has been certified by the developer to meet Apple performance standards.
- ❑ Ерөнхий тэмдэглэл: Энд хэрэглэсэн бусад бүтээгдэхүүний нэр нь зөвхөн үзүүлэнгийн зориулалттай бөгөөд зохих эзэмшигчийн худалдааны тэмдэг болно. Epson нь тэдгээр худалдааны тэмдгийн ямарваа болон бүх эрхээс татгалзана.

Энэхүү гарын авлагын тухай

Тэмдэг тэмдэглэгээ



Болгоомжтой:

Биедээ гэмтэл авахгүйн тулд анхааралтай дагах ёстой заавар.



Чухал:

Принтертээ гэмтэл учруулахаас сэргийлэхийн тулд дагах ёстой заавар.

Тэмдэглэл:

Принтерийг ажиллуулахад хэрэгтэй санамж, хоригийг агуулсан заавар.

Холбогдох мэдээлэл

➔ Энэхүү дүрсэн дээр дарвал та холбогдох мэдээллийг авах боломжтой.

Энэхүү гарын авлагад ашигласан тодорхойлолт

- ☐ Дэлгэцийн дүрслэл, зургийн дэлгэрэнгүй мэдээлэл нь загвараас шалтгаалж өөр байх боловч заавар нь ижил юм.
- ☐ Дэлгэцийн зураг нь Windows Server 2012 R2-с авсан. ҮС-ийн төрлөөс шалтгаалж дэлгэрэнгүй мэдээлэл нь өөр өөр байна.
- ☐ Цэсний зарим зүйлс загвараасаа шалтгаалаад өөр өөр байна.

Үйлдлийн системийн лавлагаа

Windows

Энэхүү гарын авлагад дурдсан "Windows 10", "Windows 8.1", "Windows 8", "Windows 7", "Windows Vista", "Windows XP", "Windows Server 2016", "Windows Server 2012 R2", "Windows Server 2012", "Windows Server 2008 R2", "Windows Server 2008", "Windows Server 2003 R2", "Windows Server 2003" зэрэг нэршил нь дараах үйлдлийн системийг илэрхийлсэн болно. Түүнчлэн, "Windows" нь бүх хувилбарыг илэрхийлнэ.

- ☐ Microsoft® Windows® 10 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® 8.1 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® 8 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® 7 үйлдлийн систем

Энэхүү гарын авлагын тухай

- ☐ Microsoft® Windows Vista® үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® XP үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows® XP Professional x64 Edition үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2016 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2012 R2 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2012 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2008 R2 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2008 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2003 R2 үйлдлийн систем
- ☐ Microsoft® Windows Server® 2003 үйлдлийн систем

Mac OS

Энэ гарын авлагат, "Mac OS" нь macOS Sierra, OS X El Capitan, OS X Yosemite, OS X Mavericks, OS X Mountain Lion, Mac OS X v10.7.x, Mac OS X v10.6.8 гэсэн хувилбарыг хэлж байгаа болно.

Оршил

Энэ бол администраторт зориулсан принтерийг ашиглах, удирдах түгээмэл гарын авлага юм.

Энэ нь түгээмэл гарын авлага учраас боломжгүй функцууд болон харагдахгүй цэс байгаа. Тиймээс мэдээлэл нь тохиргооны зүйлс эсвэл цэсийн ойролцоо өгөгдсөн.

Функцийн ашиглалтын мэдээллийг *Хэрэглэгчийн Заавар*-с үзнэ үү.

Гарын авлагын бүрэлдэхүүн

Принтерийн тохиргоо ба удирдлага

Функц бүрийг тохируулж, принтерийг удирдахын тулд сүлжээний холболтоос гарч буй урсгалыг тайлбарлана.

Холболт

Сүлжээнд төхөөрөмжийг хэрхэн холбох талаар тайлбарлана. Мөн принтер, DNS сервер болон прокси серверийн ашиглалтын портыг тайлбарлана.

Функцийн тохиргоо

Принтерийн функц бүрийг ашиглах тохиргоог тайлбарлана.

Бүтээгдэхүүний хамгаалалтын тохиргоо

Администраторын нууц үгийн тохиргоо болон хандалтын хяналт зэрэг үндсэн аюулгүй байдлын тохиргоог тайлбарлана.

Үйл ажиллагаа ба удирдлагын тохиргоо

Принтерийн мэдээллийг ба үйл явдал тохиолдоход гарах мэдэгдлийн тохиргоог шалгах зэрэг принтерийг хэрэглэж эхэлсний дараах ажиллагаа ба менежментийг тайлбарлана.

Асуудлыг шийдэх

Тохиргоонуудын эхлүүлэлт болон сүлжээний алдаа илрүүлэлтийг тайлбарлана.

Байгууллагын нарийвчилсан аюулгүй байдлын тохиргоо

SSL/TLS холбоо ба IPsec/IP шүүлтүүр гэх мэт сүлжээн дээр ашигласан дэвшилтэт аюулгүй байдлын тохиргоог тайлбарлана.

Энэхүү зааварт ашигласан нэр томъёо

Нөхцлүүд

Энэхүү зааварт дараах үг хэллэгийг ашиглана.

Оршил

Администратор

Ажлын байр эсвэл байгууллагад төхөөрөмж эсвэл сүлжээ суулгах, тохируулах ажлыг хариуцсан хүн. Жижиг байгууллагуудын хувьд, энэ хүн нь төхөөрөмж болон сүлжээний удирдлагын аль алиныг нь хариуцаж болно. Том байгууллагуудын хувьд, администраторууд нь группын хэлтэс эсвэл албаны нэгжийн сүлжээ эсвэл төхөөрөмжийг хариуцдаг бол, сүлжээний администраторууд нь Интернет г.м. байгууллагаас цааших харилцаа холбооны тохиргоог хариуцдаг.

Сүлжээний администратор

Сүлжээний харилцаа холбооны удирдлагыг хариуцдаг хүн. Интернет эсвэл сүлжээгээр дамжуулан харилцаа холбоог удирдахын тулд чиглүүлэгч, прокси сервер, DNS сервер болон шуудангийн серверийг тохируулдаг хүн.

Хэрэглэгч

Принтер эсвэл сканнер зэрэг төхөөрөмжүүдийг хэрэглэдэг хүн.

Сервер/клиент холболт (Windows сервер ашиглан принтер хуваалцах)

Сүлжээ эсвэл USB кабелиар принтерийг Windows сервер лүү холбогдсоныг заадаг холболт бөгөөд сервер дээр тохируулсан хэвлэх дарааллыг хуваалцаж болно. Серверээр дамждаг принтер болон компьютерийн хоорондын харилцаа холбоо бөгөөд принтерийг сервер дээр удирддаг.

Шууд холболт (шууд хэвлэх)

Принтер болон компьютерийг хаб эсвэл нэвтрэх цэгээр сүлжээнд холбогдсоныг заадаг холболт бөгөөд хэвлэх ажлыг компьютероос шууд хийж болно.

Web Config (төхөөрөмжийн вэб хуудас)

Төхөөрөмжид угсрагдсан вэб сервер. Үүнийг Web Config гэдэг. Та вэб хөтөч ашиглаж үүн дээрх төхөөрөмжийн төлөвийг шалгаж, өөрчлөх боломжтой.

Хэвлэх дараалал

Windows-н хувьд, принтер гэх мэт **Төхөөрөмж ба принтер** дээр гарч ирсэн порт бүрийн тэмдэг. Хэрэв төхөөрөмж стандарт TCP/IP болон WSD сүлжээ зэрэг хоёр болон түүнээс дээш порттой сүлжээнд холбогдсон бол, хоёр болон түүнээс дээш дүрсийг нэг төхөөрөмжид зориулж үүсгэнэ.

Хэрэгсэл

Epson Device Admin, EpsonNet Config, EpsonNet SetupManager зэрэг төхөөрөмжүүдийг тохируулж, удирдах Epson програм хангамжийн ерөнхий нэр томъёо.

ASCII (Мэдээлэл солилцох Америкийн стандарт код)

Стандарт тэмдэгтийн кодуудын нэг. 128 тэмдэгт тодорхойлогдсон бөгөөд үүнд цагаан толгой (a-z, A-Z), Араб тоо (0-9), тэмдэг, хоосон тэмдэгт, хяналтын тэмдэгт зэрэг тэмдэгтүүд багтана. "ASCII"-

Оршил

г энэ зааварт тайлбарлахад, энэ нь доорх 0x20–0x7E (16-тын тоо) тоог заах бөгөөд хяналтын тэмдэгтэд орохгүй.

	00	01	02	03	04	05	06	07	08	09	0A	0B	0C	0D	0E	0F
20	SP*	!	"	#	\$	%	&	'	(	)	*	+	,	-	.	/
30	0	1	2	3	4	5	6	7	8	9	:	;	<	=	>	?
40	@	A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L	M	N	O
50	P	Q	R	S	T	U	V	W	X	Y	Z	[	\	]	^	_
60	`	a	b	c	d	e	f	g	h	i	j	k	l	m	n	o
70	p	q	r	s	t	u	v	w	x	y	z	{		}	~	


* Сул зай тэмдэгт.

Unicode (UTF-8)

Дэлхийн гол хэлнүүдийг хамарсан олон улсын стандарт код. Энэхүү гарын авлагад "UTF-8"-г тайлбарлахад, энэ нь UTF-8 хэлбэрээр кодчлогдсон тэмдэгтүүдийг заана.

Сүлжээний орчны жишээ

Дундаас том хүртэлх оффисын сүлжээний орчны жишээ



(A): Интернет

Дараах үйлчилгээг принтер интернетэд холбогдох боломжтой үед ашиглаж болно.

☐ Epson Connect

Э-шуудан хэвлэлт, Алсын зайны хэвлэлт гэх мэт.

Оршил

☐ Үүлэн үйлчилгээ

Google үүлэн хэвлэлт, Evernote гэх мэт.

☐ Epson сайт

Драйвер ба програм хангамж татах ба принтерийн програмыг шинэчлэх, гэх мэт.

(B): DMZ (цэрэггүйжүүлсэн бүс)

Энэ бүс нь интернетийн сүлжээ (интранет) ба гадаад сүлжээ (интернет) хооронд байрласан ба хоёул хамгаалалттай гарцаар тусгаарласан сегмент юм. Гадаад сүлжээнд нээгдсэн серверийг тавих нь нийтлэг байдаг. Дотоод сүлжээнд учрах гадаад аюулын тархалтыг хамгаалах боломжтой. Мөн дотоод сүлжээнээс нээгдсэн сервер рүү хийх зөвшөөрөлгүй хандалтын эсрэг хамгаалах боломжтой.

☐ DNS сервер

☐ Прокси сервер

☐ Э-шуудан шилжүүлэх сервер

☐ Веб сервер

☐ FTP сервер

(C): Итгэлцлийн бүс (Интранет)

Энэ бол хамгаалалттай гарц эсвэл UTM (Нэгдсэн аюулын менежмент)-ээр хамгаалагдсан итгэлцлийн бүс.

☐ (C)-1: Интранетийн дотоод сервер

Энэ сервер нь байгууллагын компьютерт үйлчилгээ бүрийг хэрэгжүүлнэ.

☐ DNS сервер

☐ DHCP сервер

☐ Э-шуудангийн сервер

☐ Active Directory сервер/LDAP сервер

☐ Файлын сервер

☐ (C)-2: Программын сервер

Энэ сервер нь дараах байдлаар серверийн программийн функцэд хэрэглэгдэнэ.

☐ Epson хэвлэх админ

☐ Баримт авах Pro сервер

☐ (C)-3: Утастай LAN (Этернэт), (C)-4: Утасгүй LAN (Wi-Fi)

Принтер, сканнер, компьютер гэх зэргийг LAN руу LAN кабель эсвэл радио долгион ашиглан холбох.

(D): Бусад салбар

Энэ бол бусад салбарын сүлжээ. Үүнийг Интернет, түрээслэх шугам гэх мэтээр холбосон.

Сүлжээний төхөөрөмжүүд

☐ a: Хамгаалалттай гарц, UTM


☐ b: Рүүтер

☐ c: LAN шилжилт

☐ d: Утасгүй LAN удирдлага

☐ e: Нэвтрэх цэг

Жижиг оффисын сүлжээний жишээ



(A): Интернет

- ☐ Epson Connect
- ☐ Үүлэн үйлчилгээ
- ☐ Э-шуудангийн сервер, FTP сервер

(C): Итгэлцлийн бүс (Интранет)

- ☐ (B)-1: Утастай LAN (Этернэт)
- ☐ (B)-2: Утасгүй LAN (Wi-Fi)

Принтерийн холболтын төрлүүд

Принтерийн сүлжээний холболтод дараах хоёр аргыг ашиглах боломжтой байдаг.

- ☐ Сервер/клиент холболт (Windows сервер ашиглан принтер хуваалцах)
- ☐ Шууд холболт (шууд хэвлэх)

Оршил

Сервер/Клиентийн холболтын тохиргоо

Энэ бол серверийн компьютер принтертэй хуваалцдаг холболт. Серверийн компьютерийн оролцоогүйгээр холболтыг хориглохын тулд аюулгүй байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

USB ашиглаж байгаа үед сүлжээний функцгүй принтерийг мөн хуваалцаж болно.

Холболтын арга:

LAN шилжилт эсвэл хандах цэгээр принтерийг сүлжээнд холбо.

Та бас USB кабелиар сервер лүү принтерийг шууд холбож болно.

Принтерийн драйвер:

Клиент компьютерийн OS-с хамаарч Windows сервер дээр принтерийн драйверыг суулгана.

Windows сервер лүү нэвтэрч, принтерийг холбосноор, клиент компьютер дээр принтерийн драйвер сууж, ашиглах боломжтой болно.

Онцлогууд:

- ☐ Принтер болон багц дахь принтерийн драйверийг удирдана.
- ☐ Серверийн үзүүлэлтүүдээс хамаарч, хэвлэх ажлыг эхлүүлэхэд хэсэг хугацаа шаардагдаж болно. Учир нь бүх хэвлэх ажил хэвлэх серверээр дамжиж очдог.
- ☐ Windows сервер унтарсан үед та хэвлэж чадахгүй.

Холбогдох мэдээлэл

➔ [9 хуудас дээрх "Нөхцлүүд"](#)

Шууд холболтын тохиргоо

Энэ бол сүлжээн дэх принтер ба компьютерийг шууд холбох холболт юм. Зөвхөн сүлжээний чадвартай загварыг холбож болно.

Холболтын арга:

Хаб болон нэвтрэх цэгээр дамжуулан принтерийг сүлжээнд шууд холбо.

Принтерийн драйвер:

Принтерийн драйверыг клиент компьютер бүрт суулгана уу.

EpsonNet SetupManager ашиглахдаа та принтерийн тохиргоог агуулсан драйверын багцийг оруулж болно.

Онцлогууд:


- ☐ Хэвлэх ажлыг принтер лүү шууд илгээдэг тул хэвлэх ажил тэр даруйд эхэлнэ.
- ☐ Принтер ажиллаж л байвал та хэвлэж болно.

Холбогдох мэдээлэл

➔ [9 хуудас дээрх "Нөхцлүүд"](#)

Принтерийн тохиргоо ба менежмент

Принтерийн тохиргоо ба удирдлагын дараалал



A	Принтерийн сүлжээний холболт	B	Хэвлэх функцийн тохиргоо
C	Серверийн тохиргоо	D	Хамгаалалтын тохиргоо
E	Үйл ажиллагаа ба удирдлагын тохиргоо		

Принтерийн сүлжээний холболт

Принтерт IP хаягийг тохируулаад сүлжээнд холбо.

- ☐ IP хаягийн тохиргоо
- ☐ Сүлжээнд холбох (LAN кабелийн холболт/Wi-Fi тохиргоо)

Холбогдох мэдээлэл

➔ [19 хуудас дээрх "Сүлжээний холболт"](#)

Хэвлэх функцийн тохиргоо

Хэвлэх функцийг идэвхжүүлэхийн тулд тохиргоо хийнэ үү.

- ☐ Сервер/Түншийн холболтын хэвлэх тохиргоо
- ☐ Peer to Peer холболтын хэвлэх тохиргоо

Холбогдох мэдээлэл

➔ [28 хуудас дээрх "Хэвлэх функцийг ашиглах"](#)

Шуудангийн серверийн тохиргоо

Э-мэйл дамжуулах эсвэл э-мэйлийн мэдэгдэлд шуудангийн серверийн тохиргоо хийнэ үү.

- ☐ SMTP сервер
- ☐ POP3 сервер

Холбогдох мэдээлэл

➔ [38 хуудас дээрх "Шуудангийн серверийг тохируулах"](#)

Хамгаалалтын тохиргоо

- ☐ Администраторын нууц үгийн тохиргоо
- ☐ Нэвтрэлтийн хяналтын тохиргоо
- ☐ Протоколыг ашиглан хянах
- ☐ Дэвшилтэт хамгаалалтын тохиргоо

Холбогдох мэдээлэл

- ➔ [47 хуудас дээрх "Бүтээгдэхүүний хамгаалалтын тохиргоо"](#)
- ➔ [101 хуудас дээрх "Байгууллагын нарийвчилсан аюулгүй байдлын тохиргоо"](#)

Принтерийн тохиргоо ба менежмент

Үйл ажиллагаа ба менежментийн тохиргоо

- ☐ Төхөөрөмжийн төлөвийг шалгах
- ☐ Үйл явдал тохиолдоход хариу өгөх
- ☐ Төхөөрөмжийн тохиргоог нөөцлөх

Холбогдох мэдээлэл

➔ [56 хуудас дээрх “Үйл ажиллагаа ба удирдлагын тохиргоо”](#)

Сүлжээний холболт

Энэ бүлэгт принтерийг сүлжээнд холбох журмыг тайлбарлана.

Сүлжээний холболт хийхийн өмнө

Сүлжээнд холбогдохын тулд холболтын арга ба холболтын тохиргооны мэдээллийг урьдчилан шалга.

Холболтын тохиргооны талаар мэдээлэл цуглуулах

Холбохын тулд шаардлагатай тохиргооны мэдээллийг бэлд. Дараах мэдээллийг урьдчилж шалгана уу.

Ангилал	Зүйлс	Санамж
Төхөөрөмжийн холболтын арга	☐ Ethernet ☐ Wi-Fi	Принтерийг сүлжээнд хэрхэн холбохыг шийднэ үү. Утастай LAN-ий хувьд LAN шилжилт руу холбогдоно. Wi-Fi-н хувьд хандах цэгийн сүлжээнд (SSID) холбогдоно.
LAN холболтын мэдээлэл	☐ IP хаяг ☐ Дэд сүлжээний хүрээ ☐ Үндсэн гарц	Принтерт олгох IP хаягийг шийднэ үү. Та IP хаягийг хөдөлгөөнгүйгээр олгоход бүх утгууд шаардлагатай. Та DHCP функц ашиглан IP хаягийг динамикаар олгоход автоматаар тохируулагддаг тул энэ мэдээлэл шаардлагагүй.
Wi-Fi холболтын мэдээлэл	☐ SSID ☐ Нууц үг	Эдгээр нь принтер холбогддог хандах цэгийн SSID (сүлжээний нэр) ба нууц үг. Хэрэв MAC хаягийн шүүлтүүр тохируулагдсан бол принтерийг бүртгэхийн тулд принтерийн MAC хаягийг урьдчилан бүртгүүл. Дэмжигдсэн стандартуудыг Хэрэглэгчийн хөтчөөс харна уу.
DNS серверийн мэдээлэл	☐ Үндсэн DNS-н IP хаяг ☐ Хоёрдогч DNS-н IP хаяг	Статик IP хаягийг принтерт олгоход эдгээр зүйлс шаардлагатай. Системд нөөц тохиргоо ба хоёрдогч DNS сервер байгаа бол хоёрдогч DNS сервер тохируулагдана. Хэрэв танай байгууллага жижиг бөгөөд DNS сервер тохируулаагүй бол рүүтерийн IP хаягийг тохируул.
Прокси серверийн мэдээлэл	☐ Прокси серверийн нэр	Танай сүлжээний орчин интранетээс интернетэд хандахын тулд прокси серверийг болон принтер интернет рүү шууд ханддаг функцийг ашигладаг бол үүнийг тохируул. Дараах функцуудад принтер интернет рүү шууд холбогдоно. ☐ Epson Connect үйлчилгээ ☐ Бусад компаний үүлэн үйлчилгээ ☐ Үйлдвэрийн програм шинэчлэх

Сүлжээний холболт

Ангилал	Зүйлс	Санамж
Портын дугаарын мэдээлэл	☐ Гаргах портын дугаар	Принтер ба компьютерийн ашигласан портын дугаарыг шалгаад шаардлагатай бол хамгаалалттай гарцаар хаасан портыг гарга. Принтерийн ашигласан портын дугаарыг Хавсралтаас харна уу.

IP хаягийн хуваарилалт

Дараах төрлийн IP хаягийн хуваарилалт байдаг.

Байнгын IP хаяг:

Принтерт (хост) урьдчилан тодорхойлсон IP хаяг өөрөө онооно.

Сүлжээнд холбогдох мэдээллийг (дэд сүлжээний маск, үндсэн гарц, DNS сервер гэх мэт) гар аргаар тохируулах хэрэгтэй.

Төхөөрөмж унтарсан ч IP хаяг өөрчлөгдөхгүй болохоор үүнийг IP хаягийг өөрчлөх боломжгүй байгаа орчинд төхөөрөмжийг удирдахыг хүссэн үедээ эсвэл IP хаяг ашиглан төхөөрөмжийг удирдахад хэрэглэж болно. Бид олон компьютер ханддаг принтер, сервер гэх мэт зүйлд тохиргоо хийхийг зөвлөж байна. Мөн IPsec/IP шүүлтүүр зэрэг хамгаалалтын онцлогийг ашиглах үед тогтсон IP хаягийг оноож өгснөөр IP хаяг өөрчлөгдөхгүй.

DHCP функцийг (динамик IP хаяг) ашиглан автомат хуваарилалт хийх:

DHCP сервер эсвэл рүүтерийн DHCP функц ашиглан IP хаягийг автоматаар принтерт (хост) олгоно.

Сүлжээнд холбогдох мэдээллийг (дэд сүлжээний маск, үндсэн гарц, DNS сервер гэх мэт) автоматаар тохируулж өгснөөр та төхөөрөмжөө сүлжээнд хялбархан холбох боломжтой болно.

Хэрэв төхөөрөмж эсвэл рүүтер унтарсан бол, эсвэл DHCP серверийн тохиргооноос хамааран дахин холбох үед IP хаяг өөрчлөгдөж болно.

IP хаягаас бусад төхөөрөмжийг удирдах, мөн IP хаягийг дагах боломжтой протоколтой холбоотой байхыг бид зөвлөж байна.

Тэмдэглэл:

Та DHCP-н IP хаягийн захиалгын функцийг ашиглахдаа ямар ч үед ижил IP хаягийг төхөөрөмжид оноож болно.

DNS сервер болон прокси сервер

DNS серверт IP хаягийн мэдээлэлтэй хамтарсан э-шуудангийн хаягийн хостын нэр, домайны нэр гэх мэт байгаа.

Хэрэв компьютер эсвэл принтер нь IP холбоо хийж байхад нөгөө талыг хостын нэр, домайны нэр гэх мэтээр дүрсэлвэл холбоо хийх боломжгүй.

DNS серверээс тус мэдээллийг асууж, нөгөө талын IP хаягийг авна. Энэ явцыг нэрийн шийдэл гэдэг.

Тиймээс, компьютер ба принтер зэрэг төхөөрөмжүүд IP хаяг ашиглан холбогдох боломжтой юм.

Э-шуудангийн функц эсвэл интернет холболтын функц ашиглан холбогдоход принтерт нэрийн шийдэл хэрэгтэй болно.

Сүлжээний холболт

Та эдгээр функцийг ашиглахдаа DNS серверийн тохиргоог хийгээрэй.

Та DHVP сервер эсвэл рүүтерийн DHCP функц ашиглан принтерийн IP хаягийг олгоход энэ нь автоматаар тохируулагдана.

Прокси серверийг сүлжээ болон Интернет хоорондын гарц дээр байрлуулсан бөгөөд энэ нь компьютер, принтер, Интернет (эсрэг сервер) рүү тэдгээрийн тус бүрийн өмнөөс харьцдаг. Эсрэг сервер нь зөвхөн прокси сервертэй харьцдаг. Тиймээс, IP хаяг болон портын дугаар зэрэг принтерийн мэдээлэл уншигдахгүй бөгөөд аюулгүй байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Та прокси серверээр интернетэд холбогдохдоо принтер дээрх прокси серверийг тохируулаарай.

Хянах самбараас сүлжээ рүү холбох

Принтерийн хянах самбарыг ашиглан принтерийг сүлжээнд холбоно.

Принтерийн хянах самбар руу орохын тулд, *Хэрэглэгчийн Заавар* хэсгээс дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.


IP хаяг оноох

Хост хаяг, Дэд сүлжээний хүрээ, Өгөгдмөл гарц зэрэг үндсэн зүйлсийг тохируул.

Энэ хэсэгт статик IP хаяг тохируулах журмыг тайлбарлана.

Зүйлийг сонгохын тулд ▲ ▼ ◀ ▶ товч ашиглан анхаарлыг зүйлд аваачаад ОК товчийг дар.


1. Принтерийг асаана.
2. Принтерийн хянах самбар дээрх нүүр дэлгэцний **Тохиргоо** сонго.



3. **Принтерийн тохиргоо > Сүлжээний тохиргоо > Нэмэлт**-г сонго.


Сүлжээний холболт

4. TCP/IP-ийг сонго.



5. IP Хаяг Авах-н Механик гэснийг сонгоно уу.

Чиглүүлэгчийн DHCP функцийг ашиглаж IP хаягийг автоматаар тохируулахдаа та **Автомат** гэснийг сонго. Ингэсэн тохиолдолд, 6–7-р алхмын **IP хаяг, Дэд сүлжээний хүрээ, Өгөгдмөл гарц** нар мөн автоматаар тохируулагдах тул, 8-р алхам руу ор.



6. IP хаяг оруул.

Хэрэв та ◀ ба ▶ сонговол хугацаагаар тусгаарласан урд эсвэл арын сегмент рүү фокус шилжинэ.



Өмнөх дэлгэц дээр тусгагдсан утгыг баталгаажуул.

Сүлжээний холболт

7. Дэд сүлжээний хүрээ болон Өгөгдмөл гарц-г тохируул.

Өмнөх дэлгэц дээр тусгагдсан утгыг баталгаажуул.

**Чухал:**

Хэрэв IP хаяг, Дэд сүлжээний хүрээ болон Өгөгдмөл гарц-н хослол буруу байвал, **Тохируулгыг эхлүүлэх** идэвхгүй байх ба тохиргоо үргэлжлүүлэх боломжгүй. Бичилтэд алдаа байхгүй гэдгийг баталгаажуул.

8. Үндсэн DNS серверийн IP хаягийг оруул.

Өмнөх дэлгэц дээр тусгагдсан утгыг баталгаажуул.

Тэмдэглэл:

IP хаягийн шилжүүлгийн тохиргоонд **Автомат**-г сонгохдоо **Механик** эсвэл **Автомат**-н DNS серверийн тохиргоог сонгож болно. Хэрэв та DNS серверийн хаягийг автоматаар авч чадахгүй бол, **Механик** гэснийг сонгоод DNS серверийн хаягийг оруул. Дараа нь, хоёрдогч DNS серверийн хаягийг шууд оруул. Хэрэв та **Автомат** гэснийг сонгосон бол, 10-р алхам руу оч.

9. Туслах DNS серверийн IP хаягийг оруул.

Өмнөх дэлгэц дээр тусгагдсан утгыг баталгаажуул.

10. **Тохируулгыг эхлүүлэх**-ийг сонго.

11. Баталгаажуулах дэлгэцийг хаана уу.

Прокси сервер тохируулах


Хэрэв дараах зүйлс хоёул үнэн бол прокси серверийг тохируул.

- ☐ Прокси сервер нь интернет холболтод зориулагдсан.
- ☐ Epson Connect үйлчилгээ эсвэл өөр компаний үүлэн үйлчилгээ шиг принтер нь шууд интернетэд холбогддог функцийг ашиглаж байгаа бол.

1. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.


Зүйлийг сонгохын тулд ▲ ▼ ◀ ▶ товч ашиглан анхаарлыг зүйлд аваачаад ОК товчийг дар.

IP хаягийн тохиргооны дараа тохиргоо хийх үед **Нэмэлт** дэлгэц гарч ирнэ. Алхам 3 руу шилж.


2. **Принтерийн тохиргоо** > **Сүлжээний тохиргоо** > **Нэмэлт**-г сонго.

Сүлжээний холболт

3. **Прокси Сервер**-ийг сонго.



4. **Прокси Серверийн Тохиргоо**-н **Ашиглах** гэснийг сонгоно уу.



5. IPv4 ба FQDN форматаар прокси серверийн хаягийг оруул.



Өмнөх дэлгэц дээр тусгагдсан утгыг баталгаажуул.

6. Прокси серверийн портын дугаарыг оруул.
Өмнөх дэлгэц дээр тусгагдсан утгыг баталгаажуул.
7. **Тохируулгыг эхлүүлэх**-ийг сонго.
8. Баталгаажуулах дэлгэцийг хаана уу.

Сүлжээний холболт

LAN руу холбох

Принтерийг Ethernet эсвэл Wi-Fi ашиглан сүлжээнд холбоно.

Холбогдох мэдээлэл


- ➔ 25 хуудас дээрх "Ethernet рүү холбох"
- ➔ 25 хуудас дээрх "Утасгүй LAN (Wi-Fi)-д холбогдох"

Ethernet рүү холбох

Ethernet кабелийг ашиглаж принтерийг сүлжээнд холбоод холболтыг шалга.

1. Этернет кабелиар принтер ба хабыг (LAN шилжигч) холбо.
2. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд ▲ ▼ ◀ ▶ товч ашиглан анхаарлыг зүйлд аваачаад ОК товчийг дар.



3. **Принтерийн тохиргоо** > **Сүлжээний тохиргоо**-г сонгоно.
4. **Холболтыг Шалгах**-ийг сонго.

Холболтын оношлогооны үр дүн гарч ирнэ. Холболт зөв гэж баталгаажуулна уу.

5. Дуусгахын тулд **Орхих** сонго.

Принтер шалгах тайлан дээр сонгох үед, та оношлогооны үр дүнг хэвлэж болно. Үүнийг хэвлэхдээ дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

- ➔ 87 хуудас дээрх "Ethernet холболтоос Wi-Fi холболт руу солих"

Утасгүй LAN (Wi-Fi)-д холбогдох

Та принтерийн хянах самбараас нэвтрэх цэгт холбогдоход шаардлагатай мэдээллээ гараар тохируулах боломжтой. Гараар тохируулахын тулд танд SSID болон нэвтрэх цэгийн нууц үг хэрэгтэй.

Сүлжээний холболт

Тэмдэглэл:

Нэвтрэх цэг WPS-г дэмжихэд, та SSID болон нууц үгээ ашиглахгүйгээр түлхэх товч эсвэл PIN кодыг ашиглан Wi-Fi холболтын тохиргоог автоматаар хийж болно.

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд ▲ ▼ ◀ ▶ товч ашиглан анхаарлыг зүйлд аваачаад ОК товчийг дар.

2. **Рүүтэр**-ийг сонго.

3. ОК товчийг дарна уу.

Хэрэв сүлжээний холболтыг аль хэдийн тохируулсан бол холболтын дэлгэрэнгүй харагдана. Тохиргоог өөрчлөхийн тулд **Тохиргоог өөрчлөх**-г сонгоно.

Хэрэв принтерийг Ethernet-ээр аль хэдийн холбосон бол **Wi-Fi холболт руу өөрчил**. сонгож, дараа нь мессежийг баталгаажуулсаны дараа **Тийм** сонго.

4. **Wi-Fi тохируулах цонх**-ийг сонго.

5. Нэвтрэх цэгийн SSID-г сонго.

Хэрэв таны холбогдохыг хүссэн SSID принтерийн хянах самбар дээр харагдахгүй байгаа бол жагсаалтыг шинэчлэхийн тулд  товш. Хэрэв одоог хүртэл үүнийг дэлгэцэнд харуулаагүй байгаа бол -ийг сонгоод SSID-г шууд оруул.

6. **Нууц үг оруул**-г сонгоод нууц үгээ оруул.

Тэмдэглэл:

☐ Нууц үг том жижиг үсгийг ялгана.

☐ Хэрэв та SSID-г шууд оруулах бол, **Бэлэн-г Нууц үг**-д сонгоод нууц үгийг оруул.

7. Дуусаад **ЗА** сонго.

8. Тохиргоог шалгаад Тохируулгыг эхлүүлэх-г сонго.

9. Дуусгахын тулд **Орхих** сонго.

Хэрэв та холбогдож чадаагүй сүлжээний холболтын тайланг хэвлэхийн тулд **Принтер шалгах тайлан**-г сонгоод хэвлэсэн шийдлийг шалга.

10.  товчийг дарна.

Холбогдох мэдээлэл

- ➔ 68 хуудас дээрх "Сүлжээний холболтын тайлан дахь мессеж болон гарцууд"
- ➔ 84 хуудас дээрх "Хянах самбараас (WPS) Wi-Fi-н тохиргоог тохируулах"
- ➔ 88 хуудас дээрх "Wi-Fi холболтоос Ethernet холболт руу солих"

Функцийн тохиргоо

Энэ бүлэгт төхөөрөмжийн функц тус бүрийг ашиглахын тулд эхний тохиргоог хэрхэн хийхийг тайлбарлана.

Тохиргоо хийх програм

Энэ сэдвийн хүрээнд, Web Config ашиглан Администраторын компьютероос тохиргоо хийх журмыг тайлбарлана.

Web Config (Төхөөрөмжийн вэб хуудас)

Web Config-н тухай

Web Config нь принтерийн тохиргоог хийхэд зориулсан принтерийн дагалдах веб хуудас юм. Та сүлжээнд холбогдсон принтерийг компьютерээс ажиллуулах боломжтой.

Web Config-т хандахын тулд та эхлээд принтерт оноосон IP хаягтай байх хэрэгтэй.

Тэмдэглэл:

Та принтерт администраторын нууц үгийг тохируулах замаар тохиргоог түгжих боломжтой.

The screenshot displays the Epson Web Config interface. At the top, the 'EPSON' logo is on the left, and 'Administrator Logout' is on the right. Below the logo is a navigation bar with tabs: 'Status', 'Print', 'Network', 'Network Security', 'Product Security', 'Device Management', and 'Epson Open Platform'. The 'Status' tab is selected. On the left side of the 'Status' page, there is a sidebar menu with links: 'Product Status' (highlighted), 'Network Status', 'Maintenance', 'Hardware Status', and 'Panel Snapshot'. The main content area is titled 'Product Status'. It features a language dropdown menu set to 'English'. Below this, the 'Printer Status' is shown as 'Available'. A row of five ink level indicators is displayed: Black (BK), Yellow (Y), Magenta (M), Cyan (C), and a maintenance box icon. Each indicator has a corresponding level bar. Below the ink levels, there are five rows of status information: 'Black (BK):', 'Yellow (Y):', 'Magenta (M):', 'Cyan (C):', and 'Maintenance Box:'. Each row has a corresponding level bar. Below these, the 'Card Reader Status' is shown as 'Disconnected'. At the bottom, there are two sections for paper settings: 'Rear Paper Feed' and 'Cassette 1'. Each section shows 'Paper Size' as 'A4 210 x 297 mm' and 'Paper Type' as 'Plain paper'. A 'Refresh' button is located at the bottom left, and a 'Software Licenses' link is at the bottom right.

Функцийн тохиргоо

Web Config-т хандах

Принтерийн IP хаягийг вэб хөтөч рүү оруул. JavaScript идэвхжсэн байх ёстой. HTTPS-р дамжуулан Web Config-т нэвтэрч байгаа үед, принтерт хадгалагдсан өөрөө нэвтрэх эрхтэй гэрчилгээ ашиглагдах үед вэб хөтөч дээр анхааруулах мессеж гарч ирэх боловч ямар ч асуудал гарахгүй.

☐ HTTPS ашиглан хандах

IPv4: `https://<принтерийн IP хаяг> (< > тэмдэг байхгүйгээр)`

IPv6: `https://[принтерийн IP хаяг]/ ([ ]-тай)`

☐ HTTP ашиглан хандах

IPv4: `http://<принтерийн IP хаяг> (< > тэмдэг байхгүйгээр)`

IPv6: `http://[принтерийн IP хаяг]/ ([ ]-тай)`

Жишээ нь

☐ IPv4:

`https://192.0.2.111/`

`http://192.0.2.111/`

☐ IPv6:

`https://[2001:db8::1000:1]/`

`http://[2001:db8::1000:1]/`

Тэмдэглэл:

Хэрэв принтерийн нэрийг DNS сервер ашиглан бүртгүүлсэн бол та принтерийн IP хаягийн оронд принтерийн нэрийг ашиглах боломжтой.

Холбогдох мэдээлэл

➔ [103 хуудас дээрх "SSL/TLS-н принтертэй хийх харилцаа"](#)

➔ [103 хуудас дээрх "Дижитал гэрчилгээний тухай"](#)

Хэвлэх функцийг ашиглах

Сүлжээгээр хэвлэх функцийг ашиглахаар идэвхжүүлэх.

Сүлжээн дэх принтерийг ашиглахын тулд та компьютер дээрх сүлжээний холболтод болон принтерийн сүлжээний холболтод порт тохируулах хэрэгтэй.

☐ Сервер/түншийн холболт: Серверийн компьютер дээр порт тохируул

Сервер/түншийн холболтод портыг хэрхэн гар аргаар тохируулахыг тайлбарлана.

☐ Peer to peer холболт: Компьютер бүрт порт тохируул

Peer to peer холболтод програм хангамжийн диск эсвэл Epson-ий вебсайтын боломжит суурилуулагч ашиглан портыг хэрхэн гар аргаар тохируулахыг тайлбарлана.

Сервер/Түншийн холболтын хэвлэх тохиргоо

Сервер/түншийн холболтоор холбогдсон принтерээс хэвлэхийг идэвхжүүлэх.

Функцийн тохиргоо

Сервер/түншийн холболтод эхлээд хэвлэх серверийг тохируулаад, дараа нь сүлжээн дэх принтерийг хуваалц.

USB кабел ашиглан серверт холбогдохдоо мөн эхлээд хэвлэх серверийг тохируулаад, дараа нь сүлжээн дэх принтерийг хуваалц.

Сүлжээний Портыг Тохируулах

Хэвлэх сервер дээр сүлжээгээр хэвлэхэд зориулж стандарт TCP/IP-ийг ашиглан хэвлэх дараалал үүсгэсний дараа сүлжээний оролтыг тохируулна.

Дараах жишээ нь Windows 2012 R2-г ашигласан.

1. Төхөөрөмж, принтерийн дэлгэцийг нээнэ.

Десктоп > Тохиргоо > Хяналтын самбар > Техник хангамж ба дуу эсвэл **Техник хангамж > Төхөөрөмж ба принтер**.


2. Принтер нэмэх.

Принтер нэмэх дээр дарж, дараа нь **Миний нэмэхийг хүсэж буй принтерийн жагсаалтад байхгүй байна** гэснийг сонгоно.

3. Дотоод сүлжээний принтер нэмнэ.

Гар аргын тохиргоогоор дотоод сүлжээний ба сүлжээний принтер нэмэх-г сонгож, дараа нь **Дараах** дээр дарна.

4. **Шинэ порт үүсгэх**-г сонгож, дараа нь **Стандарт TCP/IP Порт**-г Портын төрлөөр сонгон, дараа нь **Дараах** дээр дарна.



5. **Хостын нэр эсвэл IP хаяг** эсвэл **Принтерийн нэр эсвэл IP хаяг** дээр принтерийн IP хаяг эсвэл принтерийн нэрийг оруулж, дараа нь **Дараах** дээр дарна.

Жишээ нь:

- ❑ Принтер нэр: EPSONA1A2B3C
- ❑ IP хаяг: 192.0.2.111

Функцийн тохиргоо

Портын нэр-г өөрчилж болохгүй.

Хэрэглэгчийн бүртгэлийн удирдлага дэлгэц гарч ирэхэд **Үргэлжлүүлэх** дээр дарна.

Тэмдэглэл:

Хэрэв та нэрийн шийдэл хийх боломжтой сүлжээгээр принтерийн нэрийг зааж өгөөгүй бол, IP хаяг нь DHCP-ээр өөрчлөгдсөн байсан ч гэлээ IP хаягийг хөөж олж болно. Та принтерийн нэрийг принтерийн хяналтын самбар дээрх сүлжээний төлөвийн дэлгэцээс эсвэл сүлжээний төлвийн хуудсыг хэвлэх замаар баталгаажуулах боломжтой.

6. Принтерийн драйверыг тохируулна.

- ☐ Принтерийн драйвер аль хэдийнэ суусан байвал:

Үйлдвэрлэгч ба **Принтер**-г сонгоно. **Дараах** дээр дарна.

- ☐ Принтерийн драйвер суугаагүй бол:

Диск байгаа дээр дарж дараа нь принтертэй хамт ирсэн програмын дискийг хийнэ. **Үзэх** дээр дарж, дараа нь принтерийн драйверыг агуулсан дискэн дээрх хавтсыг сонгоно. Зөв хавтсыг сонгосон эсэхээ баталгаажуулна. Хавтасны байрлал нь таны хэрэглэж буй үйлдлийн системээс шалтгаалаад өөрчлөгдөх магадлалтай.

Windows-н 32 битийн хувилбар: WINX86

Windows-н 64 битийн хувилбар: WINX64

7. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Сервер/клиентийн холболтоор (Windows сервер ашиглаж принтер хуваалцах) принтер ашиглаж байгаа бол, цаашдаа хуваалцах тохиргоог хийнэ.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Принтерийг хуваалцах \(Зөвхөн Windows\)"](#)

Портын тохируулгыг шалгах — Windows

Хэвлэх дараалалд зөв порт тохируулсан эсэхийг шалга.

Функцийн тохиргоо

1. Төхөөрөмж, принтерийн дэлгэцийг нээнэ.

Десктоп > Тохиргоо > Хяналтын самбар > Техник хангамж ба дуу эсвэл **Техник хангамж > Төхөөрөмж ба принтер**.

2. Принтерийн үзүүлэлтүүдийн дэлгэцийг нээ.

Принтерийн дүрсэн дээр хулганы баруун товчийг дарж, **Принтерийн үзүүлэлт**-г дарна.

3. **Портууд** таб дээр дарж, **Стандарт TCP/IP порт**-г сонгон, дараа нь **Порт тохируулах** дээр дарна.

4. Портын тохируулгыг шалгана.

☐ RAW-д зориулсан

Raw-г Протокол дээр сонгосон эсэхийг шалгаж, дараа нь **ОК** дээр дарна.

☐ LPR-н хувьд

LPR-г Протокол дээр сонгосон эсэхийг шалгана. "PASSTHRU"-г **Дарааллын нэр**-д **LPR тохиргоо**-с оруулна. **LPR байт тоололт идэвхжсэн** гэснийг сонгоод дараа нь **ОК** дээр дарна.

Принтерийг хуваалцах (Зөвхөн Windows)

Сервер/клиентийн холболтоор (Windows сервер ашиглаж принтер хуваалцах) принтер ашиглаж байгаа бол, принтерийн сервер дээрээс принтер хуваалцах тохируулгыг хийнэ.

1. Хэвлэх сервер дээрээс **Хянах самбар > Төхөөрөмж ба принтерүүдийг харах** гэснийг сонго.
2. Хуваалцахыг хүссэн принтерийн тэмдэгт (хэвлэх дараалал) дээр баруун товшоод дараа нь **Принтерийн үзүүлэлт > Хуваалцах** табыг сонгоно.

3. **Энэ принтерийг хуваалцах** сонгоод **Хуваалцах нэрийг** оруул.

Windows Server 2012-н хувьд **Хуваалцах сонголтыг өөрчлөх** товшоод дараа нь тохиргоог тохируул.

Нэмэлт драйвер суулгах (Зөвхөн Windows)

Хэрэв сервер болон клиентийн Windows хувилбарууд өөр байвал, хэвлэх серверт нэмэлт драйверуудыг суулгахыг зөвлөж байна.

1. Хэвлэх сервер дээрээс **Хянах самбар > Төхөөрөмж ба принтерүүдийг харах** гэснийг сонго.
2. Хэрэглэгч нартай хуваалцахыг хүссэн принтерийн тэмдэгт дээр баруун товшоод дараа нь **Принтерийн үзүүлэлт > Хуваалцах** таб дээр товш.

3. **Нэмэлт драйвер**-г товш.

Windows Server 2012-н хувьд, Change Sharing Options товшоод дараа нь тохиргоог тохируул.

4. Клиентийн Windows-н хувилбарыг сонгоод ОК товш.

Функцийн тохиргоо

5. Принтерийн драйверын (*.inf) мэдээллийн файлыг сонгоод дараа нь драйверыг суулга.

Холбогдох мэдээлэл

➔ [32 хуудас дээрх "Хамтын принтерийг ашиглах — Windows"](#)

Хамтын принтерийг ашиглах — Windows

Администратор принтерийн серверт оноогдсон компьютерийн нэрээр нь тухайн хэрэглэгчид үүнийг компьютертоо хэрхэн нэмэх талаар мэдэгдэх хэрэгтэй. Хэрэв нэмэлт драйверыг арай тохируулаагүй байгаа бол хамтын принтерийг нэмэхийн тулд **Төхөөрөмжүүд ба принтерүүд** гэснийг хэрхэн ашиглах талаар хэрэглэгч нарт мэдэгдэнэ үү.

Хэрэв нэмэлт драйверуудыг хэвлэх сервер дээр аль хэдийн тохируулсан бол эдгээр алхмыг дагана уу:

1. Хэвлэх серверт оноосон нэрийг **Windows Explorer** дээрээс сонго.
2. Ашиглахыг хүссэн принтер дээрээ хоёр товш.

Холбогдох мэдээлэл

➔ [31 хуудас дээрх "Принтерийг хуваалцах \(Зөвхөн Windows\)"](#)

➔ [31 хуудас дээрх "Нэмэлт драйвер суулгах \(Зөвхөн Windows\)"](#)

Peer to Peer холболтын хэвлэх тохиргоо

Peer to peer холболтод (шууд хэвлэх), принтер ба түнш нэгийг харьцах нэгийн харилцаатай байна.

Принтерийн драйверийг түншийн компьютер бүрт суулгасан байх ёстой.

Холбогдох мэдээлэл

➔ [32 хуудас дээрх "Принтерийн драйверыг суулгах — Windows"](#)

➔ [33 хуудас дээрх "Принтерийн драйверыг суулгах — Mac OS"](#)

Принтерийн драйверыг суулгах — Windows

Жижиг байгууллагын хувьд, клиент компьютер тус бүр дээр принтерийн драйверийг суулгахыг бид зөвлөж байна. Epson вэбсайт эсвэл програмын дискэн дээрх суулгагчийг ашиглана.

Тэмдэглэл:

Принтерийг олон клиент компьютероос ашиглаж байгаа үед, *EpsonNet SetupManager* ашиглаж, драйверыг багц хэлбэрээр хүргэх замаар суулгах ажиллагааны хугацааг үлэмж бууруулна.

1. Суулгагчийг ажиллуулна.

☐ Вэбсайтаас ажиллуулах


Дараах вэбсайтаас нэвтэрч бүтээгдэхүүний нэрээ оруулна уу. **Тохируулга** руу орж, програмыг татаж аваад, дараа нь үүнийг ажиллуулна.

<http://epson.sn>

Функцийн тохиргоо

- ❑ Програмын дискнээс ажиллуулна (зөвхөн диск драйвтай компьютертой хэрэглэгч болон програм хангамжийн дисктэй загваруудад зориулагдсан)
Компьютерт програмын дискийг хийнэ.

2. Принтерийн холболтын аргыг сонгоод, дараа нь **Дараах** товш.



Тэмдэглэл:

Хэрэв **Програм Суулгалтыг Сонгох** харагдаж байвал **Холболтын аргыг өөрчлөх буюу дахин тохируулах** гэснийг сонгож **Дараах** дээр товшино уу.

3. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➔ 83 хуудас дээрх "EpsonNet SetupManager"

Принтерийн драйверыг суулгах — Mac OS

Вэбсайтаас програмыг татаж аван, дараа нь компьютер нэмэх холболтын тохиргоог хийнэ.Интернэтэд орох боломжтой орчинд тохируулгыг хийж эхэлнэ.

Хэрэв та PostScript дэмждэг принтер дээр Epson PostScript принтерийн драйверийг суулгахыг хүсвэл, принтерийн *Хэрэглэгчийн Заавар*-г үзнэ үү.


1. Тохиргоо хийхийг хүсэж буй компьютероосоо дараах вэбсайт руу орж, дараа нь бүтээгдэхүүний нэрийг оруулна уу.

<http://epson.sn>

2. **Тохируулга** руу орж, улмаар програмыг татаж авна.

Функцийн тохиргоо

- Програмаа ажиллуулж, дараа нь дэлгэц дээрх зааврыг дагана.
- Additional Computer**-г Connection Type дэлгэц дээрээс сонгоно.



- Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Хэвлэх үндсэн тохиргоо

Цаасны хэмжээ эсвэл хэвлэх алдаа зэрэг хэвлэх тохиргоог тохируул.

Paper Source Settings

Цаасны эх үүсвэр тус бүрт ачаалах цаасны төрөл, хэмжээг тохируул.

- Web Config-т хандаж, дараа нь **Print** таб > **Paper Source Settings** сонго.
- Зүйл тус бүрийн тохиргоог хийнэ үү.

Гарч ирсэн зүйлс нь нөхцөл байдлаас шалтгаалан янз бүр байна.

- ☐ Цаасны эх үүсвэрийн нэр

Rear Paper Feed, Cassette 1 гэх мэт зорилтот цаасны эх үүсвэрийн нэр гарч ирнэ.

- ☐ **Paper Size**

Доош татсан цэснээс тохируулахыг хүссэн цаасны хэмжээгээ сонго.

- ☐ **Unit**

Хэрэглэгчийн тодорхойлсон хэмжээний нэгжийг сонго. Та үүнийг **User-Defined** нь **Paper Size** дээр сонгогдсон үед сонгож болно.

Функцийн тохиргоо

☐ **Width**

Хэрэглэгчийн тодорхойлсон хэмжээний хэвтээ уртыг тохируул.

Энд оруулж болох хэмжээ нь **Width**-н талд заасан цаасны эх үүсвэрээс хамаардаг.

Та **mm**-г **Unit**-с сонгохдоо нэг хүртэлх аравтын орон оруулж болно.

Та **inch**-г **Unit**-с сонгохдоо хоёр хүртэлх аравтын орон оруулж болно.

☐ **Height**

Хэрэглэгчийн тодорхойлсон хэмжээний босоо уртыг тохируул.

Энд оруулж болох хэмжээ нь **Height**-н талд заасан цаасны эх үүсвэрээс хамаардаг.

Та **mm**-г **Unit**-с сонгохдоо нэг хүртэлх аравтын орон оруулж болно.

Та **inch**-г **Unit**-с сонгохдоо хоёр хүртэлх аравтын орон оруулж болно.

☐ **Paper Type**

Доош татсан цэснээс тохируулахыг хүссэн цаасны төрлөө сонго.

3. Тохиргоог шалгаад дараа нь **OK** дар.

Холбогдох мэдээлэл

➔ [28 хуудас дээрх "Web Config-т хандах"](#)

Interface Settings

Интерфейс бүрт тогтоосон хэвлэх ажлын дуусах хугацаа ба хэвлэх хэлийг тохируул.

PCL эсвэл PostScript нийцтэй принтер дээр зүйл гарч ирнэ.

1. Web Config-т хандаж **Print** таб > **Interface Settings**-г сонго.

2. Зүйл тус бүрийн тохиргоог хийнэ үү.

3. Татаж авсан .exe файл дээр хулганаараа хоёр товш.
Epson Firmware Updater асна.
4. Дэлгэц дээрх зааврыг дагана уу.

Тохиргоог нөөцлөх

Та Web Config-с файл руу тохируулсан тохиргооны утгыг экспортолж болно. Та үүнийг тохиргооны утга нөөцлөх, принтер солих гэх мэт зүйлст ашиглаж болно.

Файлыг хоёртын файл хэлбэрээр экспортлосон тул засварлах боломжгүй.

Тохиргоог экспортлох

Принтерийн тохиргоог экспортолно.

1. Web Config-т хандаж, дараа нь **Device Management** таб > **Export and Import Setting Value** > **Export** сонго.
2. Экспортлохыг хүсэж буй тохиргоогоо сонгоно.
Экспортлохыг хүссэн тохиргоогоо сонгоно. Хэрэв та үндсэн ангиллыг сонговол, дэд ангиллууд мөн сонгогдоно. Гэлээ ч, ижил сүлжээнд (жишээ нь IP хаяг гэх мэт) хуулбарлах замаар алдаанд хүргэдэг дэд ангиллуудыг сонгож болохгүй.
3. Нууц үг оруулж, экспортолсон файлыг шифрлэнэ үү.
Танд файлыг импортлоход нууц үг хэрэгтэй. Хэрэв файлыг шифрлэхийг хүсэхгүй байгаа бол үүнийг хоосон орхи.
4. **Export** дээр дарна.



Чухал:

Хэрэв та төхөөрөмжийн нэр, IPv6 хаяг зэрэг принтерийн сүлжээний тохиргоог экспортлохыг хүсвэл, **Enable to select the individual settings of device**-г сонгоод өөр зүйлс сонго. Зөвхөн орлуулах принтерийн сонгосон утгуудыг ашиглана.

Холбогдох мэдээлэл

➔ [28 хуудас дээрх "Web Config-т хандах"](#)

Тохиргоог импортлох

Экспортлогдсон Web Config файлыг принтер рүү импортлоно.



Чухал:

Принтерийн нэр, IP хаяг гэх мэт хувийн мэдээллийг агуулж буй утгуудыг импортлохдоо, нэг ижил сүлжээн дээр адилхан IP хаяг байхгүй эсэхийг нягтлаарай. Хэрэв IP хаяг давхцаж байвал, принтер тухайн утгыг тусгахгүй.

Үйл ажиллагаа ба удирдлагын тохиргоо

1. Web Config-т хандаж, дараа нь **Device Management** таб > **Export and Import Setting Value** > **Import** сонго.
 2. Экспортлогдсон файлыг сонгоод шифрлэсэн нууц үгийг оруулна.
 3. **Next** дээр дарна.
 4. Импортлохыг хүсэж буй тохиргоогоо сонгоод **Next** дээр дарна.
 5. **OK** дээр дарна.
- Тохиргоог принтерт хийнэ.

Асуудлыг шийдэх

Асуудал шийдвэрлэх зөвлөгөө

☐ Алдааны зурвас шалгах

Асуудал гарвал эхлээд принтерийн хянах самбар эсвэл драйверын дэлгэц дээр зурвас гарч ирсэн эсэхийг шалгаарай. Асуудал гарах үед мэдэгдлийн э-мэйлийг тохируулсан бол та төлөв байдлыг цаг алдалгүй мэдэх боломжтой.

☐ Сүлжээний холболтын тайлан

Сүлжээ болон принтерийн төлвийг тогтоогоод дараа нь үр дүнг хэвлэ.

Та принтерийн хажуу талаас оношлосон алдааг олж болно.

☐ Харилцаа холбооны төлвийг шалгах

Серверийн компьютер эсвэл түншийн компьютерийн холбооны төлвийг ping ба ipconfig зэрэг команд ашиглан шалга.

☐ Холболтын тест

Принтерээс шуудангийн сервер хоорондын холболтыг шалгахдаа принтерээс холболтын тестийг хийж гүйцэтгэ. Мөн холбооны төлвийг шалгахын тулд түншийн компьютерээс сервер хүртэлх холболтыг шалга.

☐ Тохиргоог эхлүүлэх

Хэрэв тохиргоо ба холбооны төлөвт асуудал байхгүй бол принтерийн сүлжээний тохиргоог идэвхгүй болгох эсвэл эхлүүлснээр асуудлыг шийдэж болох ба дараа нь дахин тохируулна.

Принтерийн төлвийг шалгах

Асуудлын шалтгааныг тодорхойлохын тулд принтер ба сүлжээний төлвийг шалга.

Алдааны зурвас шалгах

Э-шуудангийн мэдэгдлээс алдааны зурвасыг шалгах

Э-шуудангийн мэдэгдлийг тохируулахдаа принтерээс алдааны зурвас илгээсэн болохыг шалга.

Хэрэв асуудлыг шийдэх зааварчилгаа э-шуудангийн мэдэгдэлд байгаа бол тэдгээрийг дагана уу.

Холбогдох мэдээлэл

➔ [58 хуудас дээрх "Ямар нэг зүйл болвол э-шуудангаар мэдэгдлүүд хүлээн авах"](#)

LCD дэлгэц дээрх зурвасыг шалгах

Хэрэв LCD дэлгэц дээр алдааны зурвас гарч ирвэл, дэлгэц дээрх заавар эсвэл доорх шийдлүүдийг дагаж асуудлыг шийдээрэй.

Асуудлыг шийдэх

Алдааны Зурвас	Шалтгаан ба шийдэл
Принтерийн Алдаа Принтерийг дахин асаа. Илүү дэлгэрэнгүйг баримт бичгээс харна уу.	☐ Шалтгаан: Принтерийн дотор гадны бодис байгаа эсвэл принтерийн алдаа заасан байна. ☐ Шийдэл: Принтер доторх аливаа цаас буюу хамгаалалтын материал бүгдийг гаргана. Хэрэв алдааны мессеж харагдсаар байвал Epson тусламж үйлчилгээнд хандана уу.
XX дээр цаас дууссан байна.	☐ Шалтгаан: Цаас байхгүй байна. ☐ Шийдэл: Цаасыг ачаалж, цаасан кассет-г сайтар оруулна уу.
Бэх нийлүүлэх нэгж-г солих шаардлагатай.	☐ Шалтгаан: Хор дууссан байна. ☐ Шийдэл: Та дээд зэргийн хэвлэлийн чанараар хэвлэж, өөрийн принтерийн толгойг хамгаалж байхын тулд, таны принтерийн картриджийг солих цаг болсныг илтгэх үед картриджанд бэхний аюулгүй ажиллагааны тодорхой хэмжээний нөөц үлдэнэ. Таныг картриджийг соль гэсэн бол соль.
Засвар үйлчилгээний хайрцаг танигдсангүй. Зөв суулгана уу.	☐ Шалтгаан: Арчилгааны хайрцгийг зөв суурилуулаагүй байна. ☐ Шийдэл: Арчилгааны хайрцгийн төлвийг шалгаад зөв суурилуул.
Засвар үйлчилгээний хайрцагийн үйлчилгээний хугацаа дууслаа. Солих шаардлагатай.	☐ Шалтгаан: Арчилгааны хайрцгийн үйлчилгээний хугацаа дуусах гэж байна. ☐ Шийдэл: Арчилгааны хайрцгийг удирдамжид заасны дагуу соль.
Хүчтэй цэвэрлэгээг ажиллуулахын өмнө Засвар үйлчилгээний хайрцагийг соль.	☐ Шалтгаан: Арчилгааны хайрцганд толгой цэвэрлэх хангалттай багтаамж байхгүй байна. ☐ Шийдэл: Принтерийг унтраагаад, дараа нь арчилгааны хайрцгийг соль.
Засвар үйлчилгээний хайрцагийг гаргаад дахин суулгана уу.	☐ Шалтгаан: Арчилгааны хайрцгийг зөв таниулаагүй байна. ☐ Шийдэл: Арчилгааны хайрцгийг салгаад дахин суурилуул. Эдгээрийг хийсэн ч арчилгааны хайрцаг танигдахгүй байвал шинээр соль.

Асуудлыг шийдэх

Алдааны Зурвас	Шалтгаан ба шийдэл
Цаасны тохиргоог автомат-р гаргах -ийг унтраалттай болгон тохируулав. Зарим онцлогууд ажиллахгүй байж магадгүй. Дэлгэрэнгүйг бичиг баримтаас үзнэ үү.	☐ Шалтгаан: Цаасны тохиргоог автомат-р гаргах-г салгалаа. ☐ Шийдэл: Хэрэв Цаасны тохиргоог автомат-р гаргах-г салгасан бол та AirPrint-г ашиглах боломжгүй. AirPrint ашиглах бол үүнийг идэвхжүүл.
IP хаяг болон дэд сүлжээний хүрээийн нэгдэл хүчингүй байна. Гарын авлагаас дэлгэрэнгүйг лавлаарай.	☐ Шалтгаан: Таны тохируулсан IP хаягийн хавсралт хүчингүй байна. ☐ Шийдэл: Зөв IP хаяг эсвэл өгөгдмөл гарцыг оруул.
Үүлэн үйлчилгээг ашиглахын тулд рүүт гэрчилгээг шинэчил.	☐ Шалтгаан: Үүлэн үйлчилгээнд ашигласан үндсэн гэрчилгээний хугацаа дууссан байна. ☐ Шийдэл: Web Config-г ажиллуулаад, дараа нь үндсэн сертификатыг шинэчил. Network Security — Root Certificate Update
Recovery Mode	☐ Шалтгаан: Үйлдвэрийн програмыг шинэчлэх үйлдэл амжилтгүй болж, хэвийн горимд буцах боломжгүй. ☐ Шийдэл: Фирмварийн шинэчлэл амжилтгүй болсон тул принтер сэргээх горимд эхэллээ. Доорх алхмыг дагаж фирмварийг дахин шинэчлэнэ үү. 1. Компьютер болон принтерийг USB кабелиар холбо. (Сэргээх горимын үед, фирмварийг сүлжээний холболтоор дамжуулж шинэчлэх боломжгүй.) 2. Дотоодынхоо Epson вэбсайт руу зочилж дэлгэрэнгүй зааврыг аваарай.

Алсын зайны принтерийн хавтангийн дэлгэцийг шалгах

Та Web Config ашиглан алсын зайны принтерийн хавтангийн дэлгэцийг шалгах боломжтой.

1. Шалгахыг хүссэн принтерийн Web Config-г ажиллуул.
Э-шуудангийн мэдэгдэл хүлээн авбал та э-шуудан дээрх URL-ээс Web Config-г ажиллуулж болно.
2. **Status** таб > **Panel Snapshot**-г сонгоно уу.
Одоогийн принтерийн хавтан нь Web Config дээр гарч ирнэ.
Шинэчлэхийн тулд **Refresh**-г товш.

Асуудлыг шийдэх

Сүлжээний холболтын тайланг хэвлэх

Та хэвлэгч ба нэвтрэх цэг хоорондын төлөвийг шалгахын тулд сүлжээний холболтын тайланг хэвлэх боломжтой.

1. Цаасаа ачаална.
2. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.
Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь ОК товчийг дарна.
3. **Принтерийн тохиргоо > Сүлжээний тохиргоо > Холболтыг Шалгах**-г сонго.
Холболт шалгах эхэлнэ.
4. **Принтер шалгах тайлан**-ийг сонго.
5. Сүлжээний холболтын тайланг хэвлэ.
Хэрэв алдаа заавал сүлжээний холболтын тайланг шалгаад хэвлэсэн шийдлийг дагана уу.
6. Дэлгэцийг хаана.

Холбогдох мэдээлэл

➡ [68 хуудас дээрх "Сүлжээний холболтын тайлан дахь мессеж болон гарцууд"](#)

Асуудлыг шийдэх

Сүлжээний холболтын тайлан дахь мессеж болон гарцууд

Сүлжээний холболтын тайланд гарч буй мессежүүд болон алдаа заалтуудыг харан алдааг шийдвэрлэх гарцыг дагах.

Check Network Connection

Check Result FAIL

Error code (E-7)

See the Network Status and check if the Network Name (SSID) is the SSID you want to connect.
If the SSID is correct, make sure to enter the correct password and try again.

If your problems persist,
see your documentation for help and networking tips.

Checked Items

Wireless Network Name (SSID) Check	PASS
Communication Mode Check	PASS
Security Mode Check	PASS
MAC Address Filtering Check	PASS
Security Key/Password Check	FAIL
IP Address Check	Unchecked
Detailed IP Setup Check	Unchecked

Network Status

Printer Model	XX-XXX XXX Series
IP Address	0.0.0.0
Subnet Mask	255.255.255.0
Default Gateway	
Network Name (SSID)	XXXXXXXXXXXX
Communication Mode	WPA2-PSK (AES)
Signal Strength	Poor
MAC Address	44:D2:44:DA:C0:43

a. Алдааны код

b. Сүлжээний орчин дахь мэдээлэл

E-1

Мэдээлэл:

Confirm that the network cable is connected and network devices such as hub, router, or access point are turned on.

Шийдэл:

- ☐ Ethernet кабель нь таны принтер, төв, бусад төхөөрөмжтэй найдвартай холбогдсон эсэхийг шалгах.
- ☐ Таны төв эсвэл бусад сүлжээний төхөөрөмж асаалттай байгаа эсэхийг шалгах.
- ☐ Хэрэв та принтерийг Wi-Fi-аар холбохыг хүсэж байвал идэвхгүй болсон Wi-Fi тохируулгыг принтерт хий.

Асуудлыг шийдэх

E-2, E-3, E-7

Мэдээлэл:

No wireless network names (SSID) found. Confirm that the router/access point is turned on and the wireless network (SSID) is set up correctly. Contact your network administrator for assistance.

No wireless network names (SSID) found. Confirm that the wireless network name (SSID) of the PC you wish to connect is set up correctly. Contact your network administrator for assistance.

Entered security key/password does not match the one set for your router/access point. Confirm security key/password. Contact your network administrator for assistance.

Шийдэл:

- ☐ Нэвтрэх цэгийг асаалттай байгаа эсэхийг шалгах.
- ☐ Компьютер болон төхөөрөмж нэвтрэх цэгтэй зөв холбогдсон эсэхийг нягтлах.
- ☐ Хандах цэгийг унтраана. 10 секунд хүлээгээд, дараа нь асаана.
- ☐ Принтерийг хандах цэгтэйгээ ойр байрлуулж, хооронд байрлах саадыг зайлуулна.
- ☐ Хэрвээ SSID-г гараар оруулсан бол зөв оруулсан эсэхээ шалгаарай. Сүлжээний холболтын тайлангийн **Network Status** хэсгээс SSID-г шалгаарай.
- ☐ Хэрвээ нэвтрэх цэг нь хэд хэдэн SSID-тай бол гарч ирсэн SSID-г сонго. Хэрэв SSID нь нийцэлгүй давтамж ашиглаж байгаа бол тэдгээрийг принтер автоматаар харуулахгүй.
- ☐ Сүлжээний холболт хийхдээ даралтат товчлуурын тохиргоо ашиглаж байгаа бол, таны хандалтын цэг нь WPS-г дэмждэг эсэхийг шалгана. Таны хандалтын цэг WPS-г дэмждэггүй бол та даралтат товчлуурын тохиргоо ашиглаж чадахгүй.
- ☐ Таны SSID нь зөвхөн ASCII тэмдэгт хэрэглэдэг эсэхийг шалгана (тоо, үсэг болон бусад ялгах тэмдэгтүүд). ASCII бус тэмдэгт агуулсан SSID-г принтер харуулж чаддаггүй.
- ☐ Нэвтрэх цэгтэй холбогдохын өмнө SSID болон нууц үгээ нягтал. Хэрэв та өөрийн өгөгдмөл тохиргоотой нэвтрэх цэгийг ашиглах гэж байгаа бол нэвтрэх цэг дээрх шошгон дээр байгаа SSID болон нууц үгийг ашигла. Хэрэв та SSID болон нууц үгийг мэдэхгүй бол нэвтрэх цэгийг тохируулдаг хүнтэй холбогдох эсвэл нэвтрэх цэгт өгөгдсөн бичиг баримтыг хараарай.
- ☐ Ухаалаг төхөөрөмжийн тетеринг функцээс үүсгэсэн SSID-тай холбогдож байгаа бол ухаалаг төхөөрөмжтэй дагалдан ирдэг гарын авлагаас SSID болон нууц үгийг шалга.
- ☐ Таны Wi-Fi холболт гэнэт салбал, доорх нөхцлийг шалгана. Эдгээр нөхцлийн аль нэг нь хамаарч байвал, дараах вэбсайтаас програм хангамж татаж, ажиллуулах замаар сүлжээний тохиргоогоо дахин сэргээнэ.
<http://epson.sn> > **Тохируулга**
- ☐ Түлхэх товчний тохиргоо ашиглан сүлжээнд дахин нэг ухаалаг төхөөрөмж нэмэгдлээ.
- ☐ Wi-Fi сүлжээг түлхэх товчний тохиргооноос өөр тохиргоогоор тохируулсан.

E-5

Мэдээлэл:

Security mode (e.g. WEP, WPA) does not match the current setting of the printer. Confirm security mode. Contact your network administrator for assistance.

Асуудлыг шийдэх**Шийдэл:**

Нэвтрэх цэгийн хамгаалалтын хэлбэр нь доорх тохиргоонуудын аль нэг нь байгаа эсэхийг шалга. Хэрвээ тийм биш бол хамгаалалтын хэлбэрээ нэвтрэх цэг дээрээ өөрчлөн, принтерийн сүлжээний тохиргоог дахин сэргээх шаардлагатай.

- ☐ WEP-64 бит (40 бит)
- ☐ WEP-128 бит (104 бит)
- ☐ WPA PSK (TKIP/AES)*
- ☐ WPA2 PSK (TKIP/AES)*
- ☐ WPA (TKIP/AES)
- ☐ WPA2 (TKIP/AES)

* WPA PSK-г мөн Хувийн WPA гэдэг. WPA2 PSK-г мөн Хувийн WPA2 гэдэг.

E-6**Мэдээлэл:**

MAC address of your printer may be filtered. Check whether your router/access point has restrictions such as MAC address filtering. See the documentation of the router/access point or contact your network administrator for assistance.

Шийдэл:

- ☐ MAC хаяг шүүгч нь идэвхгүй байгаа эсэхийг шалга. Хэрвээ идэвхтэй байвал принтерийн MAC хаягийг бүртгүүлж шүүлтийг болиул. Дэлгэрэнгүй мэдээллийг нэвтрэх цэгтэй хамт ирсэн баримт бичгийг үзнэ үү. MAC хаягийг сүлжээ холболтын тайлангийн **Network Status** хэсгээс шалгах боломжтой.
- ☐ Хэрвээ нэвтрэх цэгийн дундын баталгаажуулалт нь WEP -ын хамгаалалтын хэлбэрт идэвхжсэн бол баталгаажуулах түлхүүр болон индекс нь зөв байгаа эсэхийг шалга.
- ☐ Хэрвээ нэвтрэх цэг дээрх холбож болох төхөөрөмжийн тоо таны холбохыг хүссэн сүлжээний төхөөрөмжийн тооноос бага байвал, холбож болох төхөөрөмжийг тоог өсгөхийн тулд нэвтрэх цэг дээр тохиргоо хийнэ үү. Тохиргоо хийхийн тулд нэвтрэх цэгтэй хамт ирсэн баримт бичгийг үзнэ үү.

E-8**Мэдээлэл:**

Incorrect IP address is assigned to the printer. Confirm IP address setup of the network device (hub, router, or access point). Contact your network administrator for assistance.

Шийдэл:

- ☐ Принтерийн IP хаягийн тохиргоог **Автоматаар** тохируулсан бол нэвтрэх цэг дээр DHCP-г идэвхжүүл.
- ☐ Хэрвээ принтерийн IP хаягийн тохиргоог гараар тохируулсан бол, тааруулсан IP хаяг нь зохих хэмжээнээс илүү гарч хүчингүй (жишээ нь: 0.0.0.0) болсон байдаг. Принтерийн хянах самбараас эсвэл Web Config ашиглаж зөв IP хаягийг тохируул.

Асуудлыг шийдэх

Е-9

Мэдээлэл:

Confirm the connection and network setup of the PC or other device. Connection using the EpsonNet Setup is available. Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ☐ Төхөөрөмжүүд асаалттай байна.
- ☐ Принтертэй холбохыг хүссэн төхөөрөмжүүдээсээ нэг сүлжээгээр интернэт, бусад компьютер болон сүлжээний төхөөрөмжүүдтэй холбогдох боломжтой.

Принтер, сүлжээний төхөөрөмжөө холбоогүй бол, дээрхийг нягталсны дараа хандах цэгийг унтраана.10 секунд хүлээгээд, дараа нь асаана.Дараа нь, дараах вэбсайтаас суулгагч татаж, ажиллуулах замаар сүлжээний тохиргоогоо дахин сэргээнэ.

<http://epson.sn> > **Тохируулга**

Е-10

Мэдээлэл:

Confirm IP address, subnet mask, and default gateway setup. Connection using the EpsonNet Setup is available. Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ☐ Сүлжээн дээрх бусад төхөөрөмж асаалттай байна.
- ☐ Хэрвээ принтерийн IP хаягийг механикаар авахаар тааруулсан бол сүлжээний хаягууд (IP хаяг, дэд нэтийн маск, өгөгдмөл гарц) зөв гэсэн үг.

Хэрвээ эдгээр нь буруу бол сүлжээний хаягаа шинээр тохируул.Та сүлжээний холболтын тайлан дээрх **Network Status** хэсгээс IP хаяг, дэд нэт маск, өгөгдмөл гарцыг шалгах боломжтой.

Хэрэв DHCP-г идэвхжүүлсэн бол, принтерийн IP хаягийн тохиргоог **Автоматаар** авахаар өөрчил.Хэрвээ IP хаягийг механик аргаар үүсгэхийг хүсвэл сүлжээ холболтын тайлангийн **Network Status** хэсгээс принтерийн IP хаягийг шалгаж сүлжээний тохиргооны дэлгэцнээс гар аргаар оруулах гэсэн өгөгдлийг сонго.Дэд нэтийн маскыг [255.255.255.0] болгон тохируул.

Принтер, сүлжээний төхөөрөмжөө холбоогүй бол, хандах цэгийг унтраана.10 секунд хүлээгээд, дараа нь асаана.

Е-11

Мэдээлэл:

Setup is incomplete. Confirm default gateway setup. Connection using the EpsonNet Setup is available. Contact your network administrator for assistance.

Асуудлыг шийдэх

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ☐ Принтерийн TCP/IP тохируулгын тохиргоог гараар тохируулсан бол өгөгдмөл гарцын хаяг нь зөв байна.
- ☐ Өгөгдмөл гарцаар тохируулсан төхөөрөмж асаалттай байна.

Зөв өгөгдмөл гарцын хаягийг тохируул. Та принтерийн өгөгдмөл гарцын хаягийг сүлжээний холболтын тайлан дээрх **Network Status** хэсгээс шалгах боломжтой.

E-12

Мэдээлэл:

Confirm the following: -Entered security key/password is correct -Index of the security key/password is set to the first number -IP address, subnet mask, or default gateway setup is correct Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ☐ Сүлжээн дээрх бусад төхөөрөмж асаалттай байна.
- ☐ Гараар оруулж байгаа бол сүлжээний хаяг (IP хаяг, дэд нэт маск, өгөгдмөл гарц) зөв байна.
- ☐ Бусад төхөөрөмжийн сүлжээний хаягууд (дэд нэт маск ба өгөгдмөл гарц) нь мөн адилхан.
- ☐ Энэ IP хаяг бусад төхөөрөмжтэй зөрчилгүй байна.

Принтер, сүлжээний төхөөрөмжөө холбоогүй бол, дээрхийг нягталсны дараа дараахыг хийж үз.

- ☐ Хандах цэгийг унтраана.10 секунд хүлээгээд, дараа нь асаана.
- ☐ Суулгагч ашиглан сүлжээний тохиргоог дахин хийнэ.Та дараах вэбсайтаас үүнийг ажиллуулах боломжтой.

<http://epson.sn> > **Тохируулга**

- ☐ WEP хамгаалалтын хэлбэрийг хэрэглэдэг нэвтрэх цэг дээр хэд хэдэн нууц үгийг бүртгүүлэх боломжтой.Хэрвээ нэгээс дээш нууц үг бүртгүүлсэн бол эхний нууц үг нь принтер дээр тохируулсан эсэхийг шалга.

E-13

Мэдээлэл:

Confirm the following: -Entered security key/password is correct -Index of the security key/password is set to the first number -Connection and network setup of the PC or other device is correct Contact your network administrator for assistance.

Шийдэл:

Дараахыг шалгах.

- ☐ Сүлжээний төхөөрөмжүүд болох нэвтрэх цэг, төв болон роутер нь асаалттай байна.

Асуудлыг шийдэх

- ❑ Сүлжээний төхөөрөмжүүдийн TCP/IP тохиргоонуудийг механик аргаар тохируулаагүй. (Бусад сүлжээний TCP/IP тохиргоо нь гар аргаар харин принтерийн TCP/IP тохиргоо нь автомат байвал принтерийн сүлжээ нь бусад төхөөрөмжүүдийн сүлжээнээс өөр байх магадлалтай.)

Дээрхийг шалгаад ч ажиллахгүй бол дараах үйлдлүүдийг хийгээрэй.

- ❑ Хандах цэгийг унтраана. 10 секунд хүлээгээд, дараа нь асаана.
- ❑ Суулгагчийг ашиглан принтер болон компьютер хоёрын сүлжээний тохиргоог ижил болго. Та дараах вэбсайтаас үүнийг ажиллуулах боломжтой.

<http://epson.sn> > **Тохируулга**

- ❑ WEP хамгаалалтын хэлбэрийг хэрэглэдэг нэвтрэх цэг дээр хэд хэдэн нууц үгийг бүртгүүлэх боломжтой. Хэрвээ нэгээс дээш нууц үг бүртгүүлсэн бол эхний нууц үг нь принтер дээр тохируулсан эсэхийг шалга.

Сүлжээний орчин дахь мэдээлэл

Мэдээлэл	Шийдэл
*Multiple network names (SSID) that match your entered network name (SSID) have been detected. Confirm network name (SSID).	Нэг ижил SSID нь олон нэвтрэх цэг дээр тохируулсан байх магадлалтай. Тиймээс, нэвтрэх цэгээ шалгаад SSID-г өөрчил.
The Wi-Fi environment needs to be improved. Turn the wireless router off and then turn it on. If the connection does not improve, see the documentation for the wireless router.	Принтерээ нэвтрэх цэгтэй ойр байрлуулан, аливаа саадыг үгүй болгосны дараа нэвтрэх цэгээ унтраагаарай. 10 секунд хүлээгээд, дараа нь асаана. Хэрвээ холбогдохгүй бол нэвтрэх цэгтэй хамт дагалдан ирдэг гарын авлагыг хараарай.
*No more devices can be connected. Disconnect one of the connected devices if you want to add another one.	Нэгэн зэрэг холбогдож болох компьютер ба ухаалаг төхөөрөмж нь Wi-Fi Direct (Энгийн AP) холболтод бүрэн холбогдсон. Дахин өөр компьютер эсвэл ухаалаг төхөөрөмж нэмэхийн тулд холбоотой байгаа аль нэг төхөөрөмжөө эхлээд салга. Та нэгэн зэрэг холбогдож болох утасгүй төхөөрөмжийн тоо болон холбогдсон төхөөрөмжийн тоог сүлжээний төлвийн хуудас эсвэл принтерийн хаянах самбарыг шалган баталгаажуул.

Харилцаа холбооны төлвийг шалгах

Принтер ба компьютер хоорондын харилцаа холбоо зөв бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд хүргэх эсэхийг шалга.

Сервер болон сүлжээний төхөөрөмжийн бүртгэлийг шалгах

Сүлжээний холболтод ямар нэг асуудал гарвал, шуудангийн серверийн бүртгэл зэргийг баталгаажуулах, рүүтер гэх мэт системийн төхөөрөмжийн бүртгэл ба командын сүлжээг ашиглан төлвийг шалгах замаар шалтгааныг тодорхойлж болно.

Сүлжээний төлөвийн хуудсыг хэвлэх

Та үүнийг хэвлэж нарийн сүлжээний мэдээллийг шалгах боломжтой.

Асуудлыг шийдэх

1. Цаасаа ачаална.
2. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.
Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь ОК товчийг дарна.
3. **Принтерийн тохиргоо > Сүлжээний тохиргоо > Сүлжээний Статус**-г сонго.
4. **Төлөвийн Хуудсыг Хэвлэх**-ийг сонго.
5. Зурвасыг шалгаад сүлжээний төлөвийн хуудасыг хэвлэнэ.
6. Дэлгэцийг хаана.
Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

Төхөөрөмж болон компьютер хоорондын харилцаа холбоог шалгах

Ping команд ашиглан холбоог шалгах — Windows

Та Ping команд ашиглаж компьютер принтертэй холбогдсон эсэхийг шалгана уу. Ping команд ашиглан холбоог шалгахын тулд доорх алхмуудыг дага.

1. Шалгахыг хүссэн холбоогоо принтерийн IP хаягаар шалгана уу.
Та үүнийг принтерийн хянагч самбар дээр байрлах Сүлжээний төлөвийн холболтын тайлан, болон сүлжээний төлөвийн хуудсын **IP Address**-с шалгаж болно.
2. Компьютерын командын шууд дэлгэцийг харуулах.
Програмын дэлгэцийг харуулж дараа нь **Команд сануулах**-г сонгоно.
3. "ping xxx.xxx.xxx.xxx"-г оруулж дараа нь Enter товчийг дарна уу.
Принтерийн IP хаяг болох xxx.xxx.xxx.xxx-г оруулна уу.
4. Принтерийн төлвийг шалгана.
Принтер, компьютер холбогдож байвал, дараах мэдээлэл гарч ирнэ.

```

Administrator: Command Prompt

c:\>ping 192.168.111.20


Pinging 192.168.111.20 with 32 bytes of data:
Reply from 192.168.111.20: bytes=32 time=88ms TTL=64
Reply from 192.168.111.20: bytes=32 time=11ms TTL=64
Reply from 192.168.111.20: bytes=32 time=15ms TTL=64
Reply from 192.168.111.20: bytes=32 time=9ms TTL=64

Ping statistics for 192.168.111.20:
    Packets: Sent = 4, Received = 4, Lost = 0 (0% loss),
    Approximate round trip times in milli-seconds:
        Minimum = 9ms, Maximum = 88ms, Average = 30ms

c:\>_
  
```

Асуудлыг шийдэх

Принтер, компьютер холбогдоогүй байвал, дараах мэдээлэл гарч ирнэ.



```
Administrator: Command Prompt

c:\>ping 192.168.111.30

Pinging 192.168.111.30 with 32 bytes of data:
Reply from 192.168.111.10: Destination host unreachable.
Reply from 192.168.111.10: Destination host unreachable.
Reply from 192.168.111.10: Destination host unreachable.
Reply from 192.168.111.10: Destination host unreachable.

Ping statistics for 192.168.111.30:
    Packets: Sent = 4, Received = 4, Lost = 0 (0% loss),
c:\>_
```

Ping команд ашиглан холбоог шалгах — Mac OS

Та Ping команд ашиглаж компьютер принтертэй холбогдсон эсэхийг шалгана уу. Ping команд ашиглан холбоог шалгахын тулд доорх алхмуудыг дага.


1. Шалгахыг хүссэн холбоогоо принтерийн IP хаягаар шалгана уу.

Та үүнийг принтерийн хянагч самбар дээр байрлах Сүлжээний төлөвийн холболтын тайлан, болон сүлжээний төлөвийн хуудсын **IP Address**-с шалгаж болно.

2. Сүлжээний хэрэгслийг ажиллуулна уу.

Spotlight дээр "Сүлжээний хэрэгсэл"-ийг оруулна.


3. **Ping** таб дээр дарж, 1-р алхам дээр шалгасан IP хаягаа оруулан, дараа нь **Ping** дээр дарна.




Асуудлыг шийдэх

4. Принтерийн төлвийг шалгана.

Принтер, компьютер холбогдож байвал, дараах мэдээлэл гарч ирнэ.



Принтер, компьютер холбогдоогүй байвал, дараах мэдээлэл гарч ирнэ.



Компьютерийн сүлжээг шалгах — Windows

Коммандын мөрийг ашиглан компьютерийн холболтын төлөв ба принтерт очих холболтын замыг шалга. Ингэснээр та асуудлыг шийдэх болно.

Асуудлыг шийдэх

❑ ipconfig команд

Компьютерийн одоогийн хэрэглэж буй сүлжээний интерфейсийн холболтын төлвийг гарга.

Тохиргооны мэдээллийг бодит харилцаа холбоотой харьцуулан холболт зөв эсэхийг шалгаж болно. Ижил сүлжээн дээр хэд хэдэн DHCP сервер байгаа тохиолдолд та компьютерт олгогдсон бодит хаяг, хамаарал бүхий DNS сервер гэх мэт зүйлийг олж болно.

❑ Формат: ipconfig /all

❑ Жишээ:

```

c:\>ipconfig /all

Windows IP Configuration

Host Name . . . . . : WIN2012R2
Primary Dns Suffix . . . . . : pubs.net
Node Type . . . . . : Hybrid
IP Routing Enabled. . . . . : No
WINS Proxy Enabled. . . . . : No
DNS Suffix Search List. . . . . : pubs.net

Ethernet adapter Ethernet:

Connection-specific DNS Suffix . : 
Description . . . . . : Gigabit Network Connection
Physical Address. . . . . : XX-XX-XX-XX-XX-XX
DHCP Enabled. . . . . : No
Autoconfiguration Enabled . . . . : Yes
Link-local IPv6 Address . . . . . : fe80::38fb:7546:18a8:d20e%14(Preferred)
IPv4 Address. . . . . : 192.168.111.10(Preferred)
Subnet Mask . . . . . : 255.255.255.0
Default Gateway . . . . . : 192.168.111.1
DHCPv6 IAID . . . . . : 283142549
DHCPv6 Client DUID. . . . . : 00-01-00-01-20-40-2F-45-00-1D-73-6A-44-00
DNS Servers . . . . . : 192.168.111.2
NetBIOS over Tcpip. . . . . : Enabled

Tunnel adapter isatap.{00000000-ABCD-EFGH-IJKL-MNOPQRSTUUV}:

Media State . . . . . : Media disconnected
Connection-specific DNS Suffix . : 
Description . . . . . : Microsoft ISATAP Adapter #2
Physical Address. . . . . : 00-00-00-00-00-00-E0
DHCP Enabled. . . . . : No
Autoconfiguration Enabled . . . . : Yes

c:\>_

```

❑ pathping команд

Та чиглэлийн хостыг дамжин өнгөрөх рүүтерийн жагсаалт ба харилцаа холбооны рүүтерийг баталгаажуулах боломжтой.

❑ Формат: pathping xxx.xxx.xxx.xxx

❑ Жишээ: pathping 192.0.2.222

```

c:\>pathping 192.168.111.20

Tracing route to EPSONAB12AB [192.168.111.20]
over a maximum of 30 hops:
 0  WIN2012R2.pubs.net [192.168.111.10]
 1  EPSONAB12AB [192.168.111.20]

Computing statistics for 25 seconds...
Hop  RTT      Source to Here   This Node/Link   Address
 0      Lost/Sent = Pct  Lost/Sent = Pct  Address
 0      0/ 100 = 0%      0/ 100 = 0%      WIN2012R2.pubs.net [192.168.111.10]
 1  38ms      0/ 100 = 0%      0/ 100 = 0%      EPSONAB12AB [192.168.111.20]

Trace complete.

c:\>_

```

Холболтын тест хийх

Принтерээс эсвэл принтертэй ижил сегментэд холбогдсон компьютероос сервертэй хийсэн холболт ба хавтас зөв эсэхийг шалга. Ингэснээр та асуудлыг шийдэх болно.

Шуудангийн сервер

Принтерийн холболтын тест функцийг ашиглан принтер ба шуудангийн сервер хоорондын холболтыг шалга.

Холбогдох мэдээлэл

➔ [40 хуудас дээрх "Шуудангийн серверийн холболтыг шалгах"](#)

DNS сервер

Компьютерээр холбогдсон DNS серверийг шалга. Принтертэй ижил сүлжээний сегмент дээр байгаа компьютерийн сүлжээний адаптерийн төлвийг баталгаажуулаад, энэ нь принтерийн DNS тохиргоотой ижил байгаа эсэхийг баталгаажуул.

Та компьютерийн DNS тохиргоог дараах байдлаар шалгах боломжтой.

❑ Windows: **Хянах самбар > Сүлжээ ба Интернет > Сүлжээ ба Хуваалцах төв > Адаптерийн тохиргоо өөрчлөх**

Хэд хэдэн сүлжээний интерфейс байгаа үед командын мөр дээрх "ipconfig/all"-г оруулан шалгаж болно.

❑ Mac OS: **Системийн сонголт > Сүлжээ > Дэвшилтэт... > DNS**

Сүлжээний тохиргоог эхлүүлэх

Web Config-с Wi-Fi-г идэвхгүй болгох

Web Config-с Wi-Fi-г идэвхгүй болгоно. Хэрэв зарим төхөөрөмжүүд Wi-Fi-аар холбогдсон үед Wi-Fi-г идэвхгүй болговол тэд сална.

1. Web Config руу хандаад **Network** таб > **Wi-Fi**, сонгоод дараа нь **Disable Wi-Fi** сонго.
2. Мэдээллийг шалгаж, дараа нь **OK**-г сонгоно.

Web Config-аас Wi-Fi Direct (Энгийн AP)-г салгах

Web Config-аас Wi-Fi Direct (Энгийн AP)-г салга.

1. Web Config-т хандаж, дараа нь **Network** таб > **Wi-Fi Direct** сонго.
2. **Wi-Fi Direct**-н **Disable** гэснийг сонгоно уу.
3. **Next**-г товш
4. Мэдээллийг шалгаж, дараа нь **OK**-г сонгоно.

Хянах самбараас Wi-Fi-г салгах

Wi-Fi-г салгавал Wi-Fi холболт мөн сална.

Асуудлыг шийдэх

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.
Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь ОК товчийг дарна.
2. **Рүүтэр**-ийг сонго.
Сүлжээний статус харагдана.
3. **Тохиргоог өөрчлөх**-ийг сонго.
4. **Бусад > Wi-Fi-г хаах**-г сонгоно.
5. Зурвасыг шалгаад тохиргоог эхлүүлнэ.
6. Дууссан зурвас гарч ирвэл дэлгэцийг хаа.
Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.
7. 🏠 товчийг дарна.

Хянах самбараас Wi-Fi Direct (Энгийн AP) холболтыг салгах

Тэмдэглэл:

Wi-Fi Direct (Энгийн AP) холболтыг салгах үед, Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор принтерт холбогдсон бүх компьютер ба ухаалаг төхөөрөмж сална. Хэрэв та тодорхой төхөөрөмжөөс холболтоо салгахыг хүсвэл принтер биш төхөөрөмжөө салгана уу.

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.
Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь ОК товчийг дарна.
2. **Wi-Fi Direct**-ийг сонго.
Wi-Fi Direct мэдээлэл харагдана.
3. **Тохиргоог өөрчлөх**-ийг сонго.
4. **Wi-Fi Direct-г идэвхгүй болгох**-ийг сонго.
5. Зурвасыг шалгаад тохиргоог эхлүүлнэ.
6. Дууссан зурвас гарч ирвэл дэлгэцийг хаа.
Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

Принтерийн хянах самбараас Сүлжээний тохиргоог сэргээх

Та сүлжээний бүх тохиргоог үндсэн хэлбэрт нь буцааж сэргээх боломжтой.

1. Үндсэн дэлгэцээс **Тохиргоо**-г сонго.
Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь ОК товчийг дарна.

Асуудлыг шийдэх

2. **Принтерийн тохиргоо > Системийн Удирдлага > Өгөгдмөл тохиргоог сэргээх > Сүлжээний тохиргоо**-ийг сонго.
3. Мэдээллийг шалгаж, дараа нь **Тийм**-г сонгоно.
4. Дууссан зурвас гарч ирвэл дэлгэцийг хаа.
Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

Асуудлын тохиолдол

Web Config-т хандах боломжгүй

IP хаягийг принтерт олгоогүй байна.

Хүчинтэй IP хаягийг принтерт олгоогүй байна. Принтерийн хянах самбарыг ашиглан IP хаягийг тохируул. Та сүлжээний статусын хуудас ашиглан эсвэл принтерийн хянах самбараас одоогийн тохиргооны мэдээллийг баталгаажуулах боломжтой.

Веб хөтөч нь Encryption Strength-г SSL/TLS-д дэмждэггүй.

SSL/TLS нь Encryption Strength-тэй. Web Config-г дараах байдлаар бөөн шифрлэлтийг дэмждэг веб хөтчөөр нээнэ. Дэмждэг вэб хөтчийнхөө шифрлэлтийг шалгана уу.

- ☐ 80 бит: AES256/AES128/3DES
- ☐ 112 бит: AES256/AES128/3DES
- ☐ 128 бит: AES256/AES128
- ☐ 192 бит: AES256
- ☐ 256 бит: AES256

CA-signed Certificate-н хугацаа дууссан.

Хэрэв гэрчилгээний дуусах хугацаанд асуудал байгаа бол "Гэрчилгээний хугацаа дууссан" гэсэн бичиг SSL/TLS холбоотой (https) Web Config руу холбогдоход гарч ирнэ. Хэрэв энэ мессеж хугацаа дуусахын өмнө гарч ирсэн бол принтерийн огноог зөв тохируулсан эсэхээ шалгана уу.

Гэрчилгээ ба принтерийн үндсэн нэр тохирохгүй байна.

Хэрэв гэрчилгээ ба принтерийн үндсэн нэр тохирохгүй бол SSL/TLS холбоо (https) ашиглан Web Config-т хандахад "Аюулгүй байдлын гэрчилгээний нэр тохирохгүй байна" гэсэн зурвас гарч ирнэ. Дараах IP хаягууд тохирохгүй байгаа учраас ийм зүйл тохиолдоно.

- ☐ Self-signed Certificate эсвэл CSR үүсгэхэд үндсэн нэр лүү оруулсан принтерийн IP хаяг
- ☐ Web Config ажиллуулж байхад веб хөтөч рүү оруулсан IP хаяг

Self-signed Certificate-д принтерийн нэрийг өөрчил. Гэрчилгээ шинэчлэгдсэн бөгөөд принтерийг холбож болно.

CA-signed Certificate-д принтерт дахин гэрчилгээ ав.

Асуудлыг шийдэх

Дотоод хаягийн прокси серверийн тохиргоо нь веб хөтчөд тохируулагдаагүй байна.

Принтерийг прокси сервер ашиглахаар тохируулсан бол прокси серверээр дотоод хаяг руу веб хөтөч холбогдохгүй байхаар тохируул.

☐ Windows:

Хянах самбар > Сүлжээ ба Интернет > Интернет сонголтууд > Холболтууд > LAN-н тохиргоо > Прокси сервер гэснийг сонгож дараа нь LAN-д (дотоод хаягууд) прокси сервер ашиглахгүй байхаар тохируул.

☐ Mac OS:

Системийн сонголтууд > Сүлжээ > Нарийн > Проксинууд гэснийг сонгож дараа нь **Эдгээр хост ба домэйний Bypass прокси тохиргоо** хийлгэхээр локал хаягийг бүртгүүл.

Жишээ нь:

192.168.1.*: Локал хаяг 192.168.1.XXX, дэд нет маск 255.255.255.0

192.168.*.*: Локал хаяг 192.168.XXX.XXX, дэд нет маск 255.255.0.0

Холбогдох мэдээлэл

➔ [28 хуудас дээрх "Web Config-т хандах"](#)

➔ [21 хуудас дээрх "IP хаяг оноох"](#)

Хавсралт

Сүлжээний програмын танилцуулга

Дараах зүйлс нь төхөөрөмжүүдийг тохируулж, удирддаг програмыг тайлбарлана.

Epson Device Admin

Epson Device Admin нь сүлжээн дэх төхөөрөмжийг удирддаг олон талт үйл ажиллагаа бүхий програмын програм хангамж юм.

Дараах функцууд боломжтой.

- ☐ 2,000 хүртэлх принтер эсвэл сканнерийг сегментеер хянах буюу удирд
- ☐ Зарцуулалт эсвэл бүтээгдэхүүний төлөв гэх мэт зүйлст дэлгэрэнгүй тайлан хий
- ☐ Бүтээгдэхүүний үйлдвэрийн програмыг шинэчлэ
- ☐ Төхөөрөмжийг сүлжээнд таниул
- ☐ Нэгдсэн тохиргоог олон төхөөрөмжид хэрэглэ.

Та Epson дэмжлэгийн вебсайтаас Epson Device Admin-г татаж авч болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Epson Device Admin-н баримт бичиг эсвэл тусламжаас харна уу.

Epson Device Admin-г ажиллуулах (Зөвхөн Windows)

Бүх програм > EPSON > Epson Device Admin > Epson Device Admin-г сонго.

Тэмдэглэл:

Хэрэв firewall-н тэмдэг гарч ирвэл Epson Device Admin-д хандахыг зөвшөөр.

EpsonNet Config

EpsonNet Config нь сүлжээнд дэх төхөөрөмж рүү тохиргоо хийх боломжтой програмын програм хангамж юм. Төхөөрөмж нь этернэтээр сүлжээнд холбогдсон бол та IP хаяг тохируулах, холболтын аргыг өөрчлөх гэх мэт, цаашлаад IP хаягт заагаагүй төхөөрөмжид тохиргоо хийх боломжтой. Үүнийг мөн хянах самбаргүйгээр төхөөрөмжид сүлжээний тохиргоо хийхэд ашиглаж болно.

Хавсралт

Дэлгэрэнгүй мэдээллийг EpsonNet Config-н баримт бичиг эсвэл тусламжаас харна уу.



EpsonNet Config — Windows-г ажиллуулах

Бүх програм > EpsonNet > EpsonNet Config SE > EpsonNet Config-г сонго.

Тэмдэглэл:

Хэрэв firewall-н тэмдэг гарч ирвэл EpsonNet Config-д хандахыг зөвшөөр.

EpsonNet Config — Mac OS-г ажиллуулах

Очих > Програмууд > Epson Software > EpsonNet > EpsonNet Config SE > EpsonNet Config-г сонго.

EpsonNet Print (Зөвхөн Windows)

EpsonNet Print нь TCP/IP сүлжээний принтерийн програм хангамж юм. Үүнийг принтерийн драйверийн хамт суурилуулагчаас суулгасан. Сүлжээний хэвлэлт хийхийн тулд EpsonNet Print портыг үүсгэ. Онцлог үйлчилгээ болон хязгаарлалтыг доорх жагсаалтаас харна уу.

- ☐ Принтерийн төлөвийг хэвлэгчийн буфер дээр харуулна.
- ☐ Хэрэв принтерийн IP хаягийг DHCP өөрчилсөн бол принтерийг илрүүлнэ.
- ☐ Та өөр сүлжээний сегмент дээр байршсан принтерийг ашиглах боломжтой.
- ☐ Та янз бүрийн протоколуудын нэгийг ашиглан хэвлэх боломжтой.
- ☐ IPv6 хаягийг дэмждэггүй.

EpsonNet SetupManager

EpsonNet SetupManager нь энгийн принтер суулгах тухайлбал принтерийн драйвер суулгах, EPSON Status Monitor суулгах, принтерийн порт үүсгэхэд зориулсан багц үүсгэх програм хангамж юм. Энэ програм хангамж нь администраторт бүрэн цогц програм хангамжийн багц үүсгэх, түүнийгээ бүлэг дунд түгээх боломж олгоно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол бүс нутгийнхаа Epson вэбсайтаар зочилно уу.

Хянах самбараас (WPS) Wi-Fi-н тохиргоог тохируулах

Та WPS функцийг ашиглан принтерийн хянах самбараас Wi-Fi руу холбогдох боломжтой.

Холбогдох мэдээлэл

- ➔ 84 хуудас дээрх "Түлхэх товчийг тохируулж (WPS) Wi-Fi-н тохиргоог хийх"
- ➔ 85 хуудас дээрх "PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS)"

Түлхэх товчийг тохируулж (WPS) Wi-Fi-н тохиргоог хийх

Та нэвтрэх цэг дээрх товчийг дарснаар Wi-Fi сүлжээг автоматаар тохируулах боломжтой. Дараах нөхцөл биелсэн бол, та энэхүү аргыг ашиглаж тохиргоо хийх боломжтой.

- ☐ Нэвтрэх цэг нь WPS (Wi-Fi-ийн хамгаалалттай тохиргоо)-тай нийцсэн байх.
- ☐ Нэвтрэх цэг дээрх товчийг дарснаар одоогийн Wi-Fi холболтыг тогтоосон.

Тэмдэглэл:

Та товчийг олохгүй эсвэл програм ашиглан тохиргоо хийж байгаа бол, нэвтрэх цэгтэй цуг ирсэн баримт бичгийг үзнэ үү.

- Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.

- Рүүтэр**-ийг сонго.


- OK товчийг дарна.

Хэрэв сүлжээний холболтыг аль хэдийн тохируулсан бол холболтын дэлгэрэнгүй харагдана.

Wi-Fi холболт руу өөрчил. эсвэл **Тохиргоог өөрчлөх**-ийг товшиж тохиргоог өөрчилнө үү.

- Даралтат товчны тохируулга (WPS)**-ийг сонго.

- Хамгаалалтын гэрэл анивчих хүртэл нэвтрэх цэг дээрх [WPS] товчийг удаан дарна.



Хавсралт

Та [WPS] товчийг хаана байгааг мэдэхгүй байгаа бол, мөн нэвтрэх цэг дээр товч байхгүй бол, дэлгэрэнгүй мэдээллийг нэвтрэх цэгтэй цуг ирсэн баримт бичгээс үзнэ үү.

6. Принтер дээрх ОК товчийг дар.

7. Дэлгэцийг хаа.

Тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

Тэмдэглэл:

Хэрэв холболт амжилтгүй болвол үүнийг принтерт ойртуулж дахин оролдоно уу. Хэрэв ажиллахгүй бол сүлжээний холболтын тайланг хэвлэж шийдлийг шалгана уу.

8. Сүлжээний холболтын тохиргооны дэлгэцийг хаана уу.

PIN код оруулж Wi-Fi тохиргоог хийх (WPS)

Та PIN код ашиглан нэвтрэх цэгтэй автоматаар холбогдох боломжтой. Нэвтрэх цэг нь WPS (Wi-Fi-н хамгаалалттай тохиргоо)-ийн чадавхитай бол та энэхүү аргыг тохиргоо хийхэд ашиглаж болно. Нэвтрэх цэгт PIN кодыг оруулахдаа компьютер ашиглана уу.

1. Үндсэн дэлгэцээс **Wi-Fi**-г сонго.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь ОК товчийг дарна.

2. **Рүүтэр**-ийг сонго.

3. ОК товчийг дарна уу.

Хэрэв сүлжээний холболтыг аль хэдийн тохируулсан бол холболтын дэлгэрэнгүй харагдана.

Wi-Fi холболт руу өөрчил. эсвэл **Тохиргоог өөрчлөх**-ийг товшиж тохиргоог өөрчилнө үү.

4. **Бусад > PIN Код Тохируулга (WPS)**-г сонгоно

5. Принтерийн хянах самбар дээр харуулсан PIN код (8 оронтой тоо)-ыг нэвтрэх цэгт 2 минутын дотор оруулахдаа компьютероо ашигла.

Тэмдэглэл:

PIN код оруулах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэвтрэх цэгтэй цуг ирсэн баримт бичгээс үзнэ үү.

6. Принтер дээрх ОК товчийг дар.

7. Дэлгэцийг хаа.

Хэрэв та **Хаах** дээр дарахгүй бол тодорхой хугацааны дараа дэлгэц автоматаар хаагдана.

Тэмдэглэл:

Хэрэв холболт амжилтгүй болвол үүнийг принтерт ойртуулж дахин оролдоно уу. Хэрэв ажиллахгүй бол холболтын тайланг хэвлэж шийдлийг шалгана уу.

8. Сүлжээний холболтын тохиргооны дэлгэцийг хаана уу.

Wi-Fi Direct (Энгийн AP) холболт ашиглах

Wi-Fi Direct (Энгийн AP) холболт нь принтер ба төхөөрөмж руу шууд холбогддог.

Учир нь принтер нь холбогдсон сүлжээгээр дамжилгүй шууд холбогдох боломжтой, үүнийг хандах эрхгүйгээр сүлжээнд холбогдсон принтер лүү төхөөрөмжийн түр зуурын холболт хэлбэрээр ашиглаж болно.

Мөн принтерийн NFC функцийг Wi-Fi Direct (Энгийн AP) идэвхжсэн үед ашиглаж болно.

Хянах самбараас Wi-Fi Direct (Энгийн AP) идэвхжүүлэх

1. Принтерийн хянах самбар дээрх **Wi-Fi** сонгоно уу.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.

2. **Wi-Fi Direct**-ийг сонго.

Wi-Fi Direct (Энгийн AP) холболт идэвхжсэн үед Wi-Fi холболтын мэдээлэл гарч ирнэ.

3. **Тохируулгыг эхлүүлэх**-ийг сонго.

4. **Тохируулгыг эхлүүлэх**-ийг сонго.

When Wi-Fi Direct (Энгийн AP) холболт идэвхжсэн үед сүлжээ (SSID) ба нууц үг гарч ирнэ.

5. Дэлгэцийг хаа.

Тэмдэглэл:

Ухаалаг төхөөрөмжөөс, принтерийн хянах самбар дээр гарч ирсэн сүлжээ (SSID) ба нууц үгийг ашиглан принтерт холбогд.

Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог өөрчлөх

Wi-Fi Direct (Энгийн AP) холболт идэвхжсэн үед та **Wi-Fi > Wi-Fi Direct > Тохиргоог өөрчлөх**-с тохиргоог өөрчлөхөд дараах цэсийн зүйлс гарч ирнэ.

Зүйлийг сонгохын тулд, ▲, ▼, ◀, ▶ товчийг ашиглан зүйл рүү сумыг шилжүүлээд дараа нь OK товчийг дарна.

Нууц үг солих

Хэвлэгч рүү холбохдоо Wi-Fi Direct (Энгийн AP) нууц үгийг дурын утга руу өөрчилнө үү. Та хянах самбар дээрх программ хангамжийн товчлуурт гар дээр харуулсан ASCII тэмдэгтээр нууц үгийг тохируулж болно.

Нууц үгийг солих үед холбосон бүх төхөөрөмжүүд сална. Хэрэв төхөөрөмжийг дахин холбохыг хүсвэл шинэ нууц үгийг ашиглана уу.

Wi-Fi Direct (Энгийн AP)-г идэвхгүй болгох

Принтерийн Wi-Fi Direct (Энгийн AP) тохиргоог идэвхгүй болгох. Үүнийг идэвхгүй болгох үед Wi-Fi Direct (Энгийн AP) холболтоор принтерт холбогдсон бүх төхөөрөмж сална.

Хавсралт

Ухаалаг төхөөрөмжийн мэдээллийг устгах

Wi-Fi Direct (Энгийн AP)-аар холбохдоо принтерт хадгалагдсан ухаалаг төхөөрөмжийн (бүртгэгдсэн) мэдээллийг устга.

Хэрэв танд Wi-Fi Direct функцийг дэмждэг Android төхөөрөмж байгаа бол тус функцийг ашиглан принтерт холбох боломжтой. Та Wi-Fi Direct функцээр холбохдоо төхөөрөмжийг зөвшөөрсөн төхөөрөмж эсвэл татгалзсан төхөөрөмж гэж бүртгүүлвэл принтер нь төхөөрөмжийн мэдээллийг хадгална. Бүртгэлтэй төхөөрөмж дараа нь принтерийн бүртгүүлсэн мэдээллээс хамааран Wi-Fi Direct функцээр холбогдох үед зөвшөөрсөн эсвэл татгалзсан болно.

Тэмдэглэл:

Wi-Fi Direct (Энгийн AP)-г идэвхжүүлэх/идэвхгүй болгох эсвэл бүртгэлтэй төхөөрөмжийн мэдээллийг устгахын тулд та **Network** таб > **Wi-Fi Direct**-г Web Config дээрээс тохируулж болно.

Холболтын аргуудыг өөрчлөх

Холболтын аргуудыг өөрчил. Сүлжээ идэвхжүүлэх нөхцөл дээр энэ тохиргоог хий.

Хэрэв IP хаяг оноох тохиргоог гараар хийсэн бол, шинэ сүлжээнд ижил IP хаяг ашиглаж болох эсэхийг сүлжээний администратороос лавлаж баталгаажуул.

Тэмдэглэл:

Wi-Fi холболт идэвхтэй байхад Ethernet холболт идэвхгүй байна.

Холбогдох мэдээлэл

- ➔ [87 хуудас дээрх "Ethernet холболтоос Wi-Fi холболт руу солих"](#)
- ➔ [88 хуудас дээрх "Wi-Fi холболтоос Ethernet холболт руу солих"](#)

Ethernet холболтоос Wi-Fi холболт руу солих

Хянах самбараас Wi-Fi холболт руу солих

Принтерийн хянах самбараас Ethernet холболтыг Wi-Fi холболт руу соль. Өөрчилж буй холболтын арга нь Wi-Fi холболтын тохиргоотой үндсэндээ адил байна. Принтерийн хянах самбараас Wi-Fi холболтын тохиргоо хийх энэхүү гарын авлага дээрээс тухайн сэдвийг үзнэ үү.

Холбогдох мэдээлэл

- ➔ [25 хуудас дээрх "Утасгүй LAN \(Wi-Fi\)-д холбогдох"](#)

Web Config ашиглаж Wi-Fi холболт руу солих

Web Config ашиглаж Ethernet холболтоос Wi-Fi холболт руу соль.

1. Web Config-т хандаж, дараа нь **Network** таб > **Wi-Fi** сонго.

Администраторын нууц үг тохируулсан үед, хэрэглэгчийн нэр болон нууц үгийг оруулж администратор хэлбэрээр нэвтэр.

2. **Setup** дээр дарна.

Хавсралт

3. Нэвтрэх цэгийн SSID-г сонгоод нууц үгийг оруулна.

Хэрэв таны холбогдохыг хүссэн SSID харагдахгүй байгаа бол **Enter SSID**-г сонгоод SSID-г оруул.

4. **Next** дээр дарна.

5. Гарч ирсэн мэдээллийг баталгаажуулаад **OK** дээр дар.

6. Ethernet кабелийг принтерээс салга.

Тэмдэглэл:

Мөн та холболтын аргыг *Epson Device Admin* ашиглан өөрчлөх боломжтой. Дэлгэрэнгүйг гарын авлага эсвэл *Epson Device Admin* тусламжаас аваарай.

Холбогдох мэдээлэл

- ➔ 28 хуудас дээрх "Web Config-т хандах"
- ➔ 82 хуудас дээрх "Epson Device Admin"

Wi-Fi холболтоос Ethernet холболт руу солих

Хянах самбараас Сүлжээний тохиргоог Ethernet болгон өөрчлөх

